D. Халууралт

E. Маш хүнд халууралт өвчин

/133./ Хүүхэд хэдэн наснаас инээмсэглэж сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг вэ?

- A. 1 сар
- B. 1.5 сар
- C. 2.5 сар
- D. 3 сар
- E. 4 сар

/134./ 6-12 сартай хөхөө хөхдөг хүүхдэд нэмэгдэл хоолнуудад дасгасны дараа өдөрт хэдэн удаа нэмэлт хоол өгөх вэ?

- A. 1-2 удаа
- B. 3 удаа
- C. 5 удаа
- D. 4 удаа
- E. 6 удаа

/135./ 38,5 хэмээс дээш хэлуурч буй 8 сартай хүүхдэд парацетамолын 100 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?

- A. 1\4
- B. 1\2
- C. 1 бүтнээр
- D. 1.5
- E. 2 бүтнээр

/136./ Шуугиантай амьсгалтай уушгины хатгалгаатай 10 сартай хүүхдэд сальбутамолыг яаж өгөх вэ?

- A. 4 мг шахмалаас 1/4 шахмалаар өдөрт 3 удаа, 5 хоног
- B. 4 мг шахмалаас 1/2 шахмалаар өдөрт 3 удаа 5 хоног
- C. 2 мг шахмалаас 1 шахмалаар өдөрт 2 удаа 5 хоног
- D. 2 мг шахмалаас 1+1/2 шахмалаар өдөрт 2 удаа 5 хоног
- E. 2 мг шахмалаас 1/2 шахмалаар өдөрт 5 удаа 3 хоног

/137./ Ургийн хөгжлийн хэд дэх 7 хоногт мэдрэлийн тогтолцоо үүсч эхэлдэг вэ?

- A. Эхний 7 хоногт
- B. 2 дахь 7 хоногт
- C. 3 дахь 7 хоногт
- D. 4 дэх 7 хоногт
- E. 5 дахь 7 хоногт

/138./ Хүйг хэрхэн цэвэрлэх вэ?

- 1. Хүйнд юу ч түрхэхгүй
- 2. Хуурай цэвэр байлгана
- 3. Агаарт ил, боолтгүй байлгана
- 4. Антибиотик хэрэглэнэ
- 5. Халдваргүйжүүлэх уусмал хэрэглэнэ

/139./ Ханиалга намдаах, хоргүй зөөлөн эм аль нь вэ?

- 1. Зөвхөн хөхөөрөө нялхаст хөхний сүү
- 2. Аньсны ханд
- 3. Зөгийн балтай сүү
- 4. Чигатуссин
- 5. Уротропин

/140./ Шингэн алдалт бүхий суулгалттай хүүхдийг яаж эмчлэх вэ?

- 1. Б төлөвлөгөөгөөр эмчил
- 2. Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлө
- 3. Сайжрахгүй бол 5 хоноод давтан үзүүл
- 4. А төлөвлөгөөгөөр эмчил
- 5. В төлөвлөгөөгөөр эмчил

/141./ Маш хүнд халууралт гэж ангилсан бол ямар арга хэмжээ авах вэ?

- 1. Эмнэлэгт яаралтай хэвтүүл
- 2. Хүүхдийг цусны чихэр багасахаас сэргийлж эмчил
- 3. Тохирох антибиотикийн эхний тунг өг
- 4. Халуун 38°C халуурсан бол парацетамол өг
- 5. Хэрэв нүд нуухтсан бол тетрациклины тос түрх

/142./ Хөхөө зөв үмхсэний шинжийг нэрлэнэ үү?

1. Эрүү хөхөнд хүрсэн
2. Амаа том ангайсан
3. Доод уруул цорвойсон
4. Хөхний нөсөөт хэсэг амны дээр илүү харагдана
5. Доод уруул дотогш эргэсэн

/143./ Хэрэв маш хүнд халууралт өвчин гэж ангилсан бол

1. Тохирох антибиотикийн эхний тунг өгнө
2. Цусны чихэр багасахаас сэргийлж эмчилнэ
3. Өндөр халуунтай бол парацетамол өгнө
4. Эмнэлэгт ЯАРАЛТАЙ хэвтүүлнэ
5. Гэрээр антибиотикоор эмчилнэ

/144./ Уушгины хатгалгаагүй, ханиад шуухинаатай хүүхдийг яаж эмчлэх вэ?

1. 30-аас олон хоног ханиалгасан бол онош тодруулахаар эмнэлэгт хэвтүүл
2. Хоргүй зөөлөн эмээр хоолойн өвдөлт ханиалгыг эмчил
3. Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлө
4. Сайжрахгүй бол 5 хоноод давтан үзүүл
5. Эмнэлэгт яаралтай хэвтүүл

/145./ 6 сар хүртэлх эрүүл ба өвчтэй хүүхдийн хооллолтын зөвлөмж?

1. Хүүхдийг хүссэн үед нь аль болох олон удаа өдөр шөнөгүй хоногт 8-аас доошгүй хөхүүл
2. Хүүхэд цадаж хөхөхөө больтол нь хөхүүл
3. Эхний 6 сар дан хөхөөр хоолло
4. Өөр хоол буюу шингэн бүү өг
5. Шөнө хөхүүлэх шаардлагагүй

/146./ А төлөвлөгөөний үед эхэд зөвлө

1. Шингэнийг аяганаас бага багаар ойр ойрхон шимүүлж өг
2. Хүүхэд бөөлжвөл 10 хүлээгээд илүү аажим үргэлжлүүлэн өг
3. Суулгалт зогсох хүртэл шингэнийг өг
4. Цайрын бэлдмэл 14 хоног өг
5. ШСД-ны уусмал 4 цагийн турш өг

/147./ Суулгалттай хүүхдийг хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлөх вэ?

1. Халуурах
2. Уухдаа муу болох
3. Баас цустай болох
4. Бие нь муудах
5. Хөлрөх

/148./ Чихэнд булагтай, булаг гараад 20 хонож байгаа хүүхдийн өвчнийг ангилж, эмчилгээг тогтоо

1. Чихний архаг халдвар
2. Кюнолоныг 14 хоног чихэнд дусаах
3. Чихийг чихээсээр хуурайшуул
4. 5 хоноод давтан үзүүл
5. Парацетамолыг өг

/149./ Хүнд тураал гэж ангилах шинжүүдийг сонгоно уу?

1. Илт туранхай
2. Хоёр хөлд хавантай
3. Бугалганы тойрог <110 мм
4. Алга хувхай цагаан
5. Насанд тохирох жин бага

/150./ 2 сараас 5 хүртэлх насны хүүхдэд илрэх аюултай ерөнхий шинжүүдийг сонгоно уу?

1. Хүүхэд ууж буюу хөхөж чадахгүй
2. Хүүхэд уусан бүхнээ бөөлжих
3. Хүүхэд энэ өвчний үед татах
4. Хүүхэд унтаарсан буюу ухаангүй
5. Хүүхэд ховдоглон уух

/151./ Маш хүнд өвчин гэж ангилагдсан нярайн эмчилгээг тогтоо

1. Антибиотикийн эхний тунг булчинд тарь
2. Цусны чихэр багасахаас сэргийлж эмчил
3. Замд хүүхдээ дулаан авч явахыг эхэд зөвлө
4. Эмнэлэгт яаралтай хэвтүүл
5. Антибиотик 5 хоног уулга

/152./ Төрөх тасагт буюу 24-48 цагийн дотор хийх вакцин аль нь вэ?

1. Сүрьеэ
2. Халдварт саа
3. Хепатит В
4. Тавт вакцин
5. Сахуу, хөхүүл ханиад, татран

/153./ Суулгалтын үеийн гэрийн эмчилгээний зарчмыг хэлнэ үү?

1. Шингэн илүү уулга
2. Үргэлжлүүлэн хоолло
3. Хэзээ эргэж үзүүлэхийг эхэд зөвлө
4. Цайрын бэлдмэл өг
5. Хоолыг тодорхой хугацаагаар сой

/154./ Ужиг суулгалтыг хэрхэн ангилах вэ?

1. Шингэн алдалтгүй ужиг суулгалт
2. Ужиг суулгалт
3. Шингэн алдалттай ужиг суулгалт
4. Хүнд ужиг суулгалт
5. Шингэн их алдалттай ужиг суулгалт

/155./ Чихний өвчинг хэрхэн үнэлэх вэ?

1. Чих өвдөж байгаа эсэхийг асууна
2. Чихнээс булаг гарч байгаа эсэхийг асууна
3. Чихний ард хөндүүр, хавдсан эсэхийг тэмтэрч үзнэ
4. Чихнээс хэд хоног булаг гарч байгааг тодруулна
5. Чихний ард хавдсан эсэхийг асууна

/156./ Дараах шинжүүдээс аль нь хүнд хүндрэл бүхий улаан бурхан гэж ангилах шинж вэ?

1. Аюултай ерөнхий шинжээс аль нэг нь илрэх
2. Эвэрлэг бүдгэрсэн
3. Амны гүнзгий, өргөн шархлаа
4. Нүднээс нуух гоожих
5. Халуурах

/157./ Амьсгал олширсоны босго аль нь вэ?

1. 2 сар хүртэлх нярайд 60 буюу түүнээс олон
2. 2 сараас 12 сар хүртэл 50 буюу түүнээс олон
3. 12 сараас 5 хүртэлх насанд 40 буюу түүнээс олон
4. 2 сараас 12 сар хүртэл 40 буюу түүнээс олон
5. 12 сараас 5 хүртэлх насанд 50 буюу түүнээс олон

/158./ Хүүхэд сүүлийн 3 сард эсвэл одоо улаанбурхантсан бол хэрхэн үнэлэх вэ?

1. Амны шархлааг ажиглана
2. Нүдний эвэрлэг бүдгэрсэн эсэх шалгана
3. Нүднээс нуух гарч байгаа эсэх ажиглана
4. А-аминдэм өгнө
5. Парацетамол өгнө

/159./ А төлөвлөгөөгөөр суулгалт бүрийн дараа буюу хооронд хэдий хэмжээний шингэн уулгах вэ?

1. 2 нас хүртэл 100-200 мл
2. 2 нас хүртэл 50-100 мл
3. 2-оос дээш насны хүүхдэд 100-200 мл
4. 2 буюу түүнээс дээш 100-200 мл
5. Хүссэн хэмжээгээр нь өгөх

/160./ 3 настай ханиалгаж байгаа хүүхдийн амьсгал 1 мин-д 48 байв. Түүний амьсгал олширсон уу? Хэрхэн ангилах вэ?

1. Амьсгал олшроогүй
2. Амьсгал олширсон
3. Ханиад шуухинаа
4. Уушгины хатгалгаа
5. Уушгины хүнд хатгалгаа

/161./ ХӨЦМ-ийн дагуу ханиад шуухинаа гэж ангилсан хүүхдэд ямар шинж илэрвэл яаралтай үзүүлэхийг зөвлөх вэ?

1. Уух буюу хөхөхдөө муудах
2. Өвчин хүндрэх
3. Халуурах
4. Амьсгал олшрох
5. Амьсгал саадтай болох

/162./ Чихнээс булаг гараад 15 хоносон 6 сартай хүүхэд 38оС халуунтай, чээж нь хонхолзож байв. Хүүхдийн эмчилгээг тогтоо

1. Тохирох антибиотикийн эхний тунг өгнө
2. Цусны чихэр багасахаас сэргийлж эмчилнэ
3. Эмнэлэг яаралтай хэвтүүлнэ
4. Парацетамол өгнө
5. 2 хоноод давтан үзнэ

/163./ 1-2 нас хүртэлх эрүүл ба өвчтэй хүүхдийн хооллолтын зөвлөмж?

1. Хүүхдийг хүссэн үед нь аль болох олон удаа хөхүүл
2. Нэг удаад 250-300 мл тохирсон хоолыг бэлтгэж өгөх
3. Гэрийнхний хоолны өтгөн хэсгийг жижиглэж нухаад өгөх
4. Ногоо жимс өгөх
5. Өдөрт 3-4 удаа нэмэгдэл хоол, 1-2 удаа зууш өгөх

/164./ Ямар тохиолдолд МАШ ХҮНД ХАЛУУРАЛТ гэж ангилах бэ?

1. Хүүхэд амны өргөн гүнзгий шархлаатай
2. Хүзүүний хөшингө илэрсэн
3. Хүүхдийн халуун 40С хүрсэн
4. Унтаарсан байдалтай
5. Хүүхэд унаж татдаг

/165./ Хүүхдэд 9 сартайд нь ямар вакцин хийх вэ?

1. Улаан бурхан
2. Улаанууд
3. Гахайн хавдар
4. Тавт вакцин
5. Саагийн эсрэг вакцин

/166./ Ямар шинжүүдийг үндэслэн чихний цочмог халдвар гэж ангилах вэ?

1. Чихнээс булаг 14 хоногоос удаан гоожсон
2. Чих өвдөх
3. Халуурах
4. Чихэнд булаг харагдах ба булаг гараад 14 хоноогүй
5. Чихний ард хавдсан, хөндүүр

/167./ Рахитыг хэрхэн үнэлэх вэ?

1. Хүүхдийн булчингийн хүчдлийг шалгана
2. Хүүхэд хөхөө хөхөх, унтахдаа хөлөрдөг эсэхийг асууна
3. Хүүхдийн гавалын яс зөөлөрсөн эсэхийн шалгана
4. Шээс үнэртэй гарч байгаа эсэхийг асууна
5. "Сампингийн эрхи"-ийн шинжийг шалгана

/168./ Суулгалт өвчин эхэлмэгц

1. Суулгалтыг хүндрүүлэх учраас шингэн уулгахаа болих
2. Хөхөө олон дахин хөхүүлэх
3. Суулгалтын эсрэг эм уулгах
4. Гэрээр зөвлөдөг шингэн уулгах
5. Хоол сойх

/169./ Халууралт гэж ангилсан бол

1. 38.5оС дээш халуунтай бол парацетамол өгнө
 2. Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлөнө
 3. Хэрэв хүүхэд 5 буюу түүнээс олон хоног халуурсан бол онош тодруулахаар эмнэлэгт хэвтүүлнэ
 4. Халууралт намжихгүй бол 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
 5. Халуурсан тохиолдол бүрт халуун бууруулах эм өгнө
- /170./ Нярайд ямар шинж илэрвэл нянгийн хэсэг газрын халдвар гэж ангилах вэ?
1. Чээж хүчтэй хонхолзох
 2. Хүй улайсан буюу идээ гарсан
 3. Ханиалгах, халуурах
 4. Арьсан дээгүүр идээт цэврүү гарах
 5. Унтаарсан буюу ухаангүй
- /171./ Түгээмэл тууралттай, нүднээс нуух гоожсон хүүхдийн эмчилгээг тогтоо.
1. А аминдэм өг
 2. Тетрациклины тосоор нүдны халдварыг эмчил
 3. 2 хоноод давтан үзүүл
 4. Хэрэв татвал яаралтай эргэж ирэх
 5. Хэрэв халуун буурахгүй бол эргэж ир
- /172./ Уушгины хатгалгаатай хүүхдийн эмчилгээг тогтооно уу?
1. Тохирох антибиотیکیг 3-5 хоног өгөх
 2. Хоргүй зөөлөн эмээр хоолойн өвдөлт ханиалгыг эмчлэх
 3. Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлөх
 4. 2 хоноод давтан үзүүлэх
 5. Сайжрахгүй бол 2 хоноод давтан үзүүлэх
- /173./ Чихэнд булагтай, булаг гараад 10 хонож байгаа хүүхдийн өвчнийг ангилж, эмчилгээг тогтоо
1. Чихний цочмог халдвар
 2. Тохирох антибиотیکیг 5 хоног өг
 3. Чихийг чихээсээр хуурайшуул
 4. 5 хоноод давтан үзүүл
 5. Парацетамолыг өг
- /174./ Тавт вакциныг хэдэн сартайд хийх вэ?
1. 2 сартайд
 2. 3 сартайд
 3. 4 сартайд
 4. 9 сартайд
 5. 2 насанд
- /175./ Суулгаж байгаа нэмэгдэл хоолонд орсон хүүхдэд алийг нь зөвлөх вэ?
1. ШСД-ны уусмал
 2. Тараг хоормог
 3. Шөл
 4. Цагаан будааны шүүс
 5. Давстай ус
- /176./ Нүд буюу амны хүндрэлтэй улаан бурхан гэж ангилсан бол
1. А-аминдэм өгнө
 2. Хэрэв нүднээс нуух гоожсон бол тетрациклины тосоор нүдний халдварыг эмчилнэ
 3. Хэрэв амны шархлаатай бол генцианвиолетээр эмчилнэ
 4. 2 хоноод давтан үзнэ
 5. Эхэд хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөнө
- /177./ Халууралтыг хэрхэн үнэлэх вэ?
1. Нүднээс нуух гарч байгаа эсэхийг ажиглана
 2. Түгээмэл тууралтыг ажиглана
 3. Нүдний эвэрлэг бүдгэрсэн эсэхийг шалгана
 4. Хүзүүний хөшингийг шалгана
 5. Амны шархлааг шалгана
- /178./ Цусан суулгалттай хүүхдийг ямар тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэх вэ?

1. 12 сар хүрээгүй
2. Шингэн алдалттай
3. Сүүлийн 3 сард улаанбурханаар өвчилсөн
4. Тэжээвэр
5. Урьд нь суулгалтаар өвчилж байсан

/179./ Ямар тохиолдолд халууралтыг үнэлэх вэ?

1. Халуурсан мэдүүлэгтэй
2. Тэмтрэхэд бий нь халуун
3. Суганы халуун 37.5OC
4. Ханиалгасан
5. Суулгасан

/180./ Аюултай ерөнхий шинжүүдийг сонгоно уу?

1. Уух буюу хөхөх чадваргүй
2. Татах
3. Унтаарсан буюу ухаангүй
4. Хяхатнаж амьсгалах
5. Амьсгал олшрох

/181./ 6-12 сар хүртэлх эрүүл ба өвчтэй хүүхдийн хооллолтын зөвлөмж?

1. Хүүхдийг хүссэн үед нь аль болох олон удаа хөхүүл
2. Нэг удаад ойролцоогоор 200 мл тохирсон хоолыг бэлтгэж өгөх
3. Хүүхэд хөхөөр хооллодог бол 6-8 сартайд 2-3 удаа нэмэлт хоол өгөх
4. Хүүхэд хөхөөр хооллодог бол 9-12 сартайд 3-4 удаа нэмэлт хоол өгөх
5. Хөхөөр хооллодоггүй бол өдөрт 5 удаа нэмэлт хоол өгөх

/182./ Хэрэв хүүхдийг хүнд тураал буюу хүнд цус багадалт гэж ангилсан бол дараах арга хэмжээг авна

1. Төмрийн бэлдмэл өндөр тунгаар өгнө
2. Цусны чихэр багасахаас сэргийлж эмчилнэ
3. Бичил тэжээлийн холимог өгнө
4. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
5. Судсаар тэжээлийн уусмал яаралтай хийнэ

/183./ Уушгины хатгалгааны үед хангалттай хүчилтөрөгч авч чадахгүй учраас хүүхдийн амьсгалын тоо олширно.

/184./ Нярай хүүхдийн баас цустай гарах нь зөвхөн цусан суулгын шинж учраас гэрт нь эмчилнэ.

/185./ Рахитын үед яс зөөлөрснөөс “сампингийн эрхи”-ийн шинж илэрнэ.

/186./ Хүнд цус багадалтын үед цусны онкос даралт буурснаас гарын алга хувхай цайна.

/187./ Тайван биш цочромхой, ховдоглон ууж байгаа суулгалттай хүүхдийг шингэн алдалттай гэж ангилах учраас эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

/188./ Зөв найруулсан ШСД-ны уусмал нь хэт өтгөрүүлэгтэй байдаг тул суулгалтыг намжаана.

/189./ Шингэн их алдалттай 5 кг жинтэй хүүхдийг Б төлөвлөгөөгөөр эмчлэх учраас эхний 1 цагт 350 мл Рингер лактатын уусмал хийнэ.

/190./ Уушгины хүнд хатгалгааны үед уушги хөшүүн болох учраас цээж хонхолзоно.

/191./ Маш хүнд өвчний үед цусны чихэр багсах учраас эмнэлэгт хэвтүүлэхийн өмнө чихэртэй ус уулгана.

/192./ Хүнд тураалын үед өгзөгний өөхлөх арилах учраас “элбэг өмд”-ний шинж илэрнэ.

/193./ Төрөх замаар төрсөн нярай нүдний халдварт өртөх эрсдэлтэй байдаг тул нүдэнд нь тетрациклины нүдний тос хавчуулна.

/194./ Уушгины хатгалгааны үед уушги хөшүүн болох учраас шуугиантай амьсгалтай амьсгал сонсогдоно.

/195./ Хүүхдийн халуун 38.5оС байвал өндөр халуун учраас парацетамол өгнө.

/196./ Гистамины эсрэг I үеийн эмийн гаж нөлөө

1. Үйлчилгээ богино
2. Салст хуурайшуулах
3. Нойр хүргэх
4. Дасал болох
5. Шээс багасах

/197./ Дархлаа урвалж чанарын онцлогоос шүүдэст эмзэгшилтэй хүүхдэд эмнэлзүйн дараах онцлог илэрнэ

1. Хүзүүний тунгалгийн булчирхайнууд томрох
2. Дисбактериозтой байх
3. Халдварт өртөмхий
4. Хүүхдийн баас тогтворгүй
5. Биеийн жин тогтворгүй

/198./ ГХБ өвчний үед шуугиант амьсгал үүсэх механизм

1. Гуурсан хоолой өтгөн салсаар бөглөрөх
2. Гуурсан хоолойн гилгэр булчин агчих
3. Гуурсны салст хөөж хавагнах
4. Гуурсан хоолой гаднаасаа дарагдах
5. Гуурсан хоолойд гадны биет орох

/199./ Ужиг ГХБ-ны барих эмчилгээнд хэрэглэгддэг эмийн бүлэг:

1. Ингальяционные кортикостероиды
2. Кромогликат натрия , недокромил натрия
3. Удаан үйлчилгээтэй В2 агонисты
4. Удаашруулсан үйлчилгээтэй теофиллин
5. Лейкотриены хүлээн авуур саатуулагч

/200./ Дараах эмүүдээс аль нь нойрсуулах нөлөөгүй вэ?

1. Кларотадин
2. Цитеризин
3. Телфаст
4. Левоцитеризин
5. Хлорфенирамин

/201./ Эуфиллины үйлчлэх механизм юу вэ?

1. Гуурсны гилгэр булчин сулруулна
2. Уушгины артерийн даралт бууруулна.
3. Титэм судас өргөсгөнө
4. Бөөрний судас өргөсгөж, шээс ялгаралтыг сайжруулна
5. Даралт бууруулна

/202./ Шүүдэст эмзэгшлийн тууралтын онцлог:

1. Халдварт өртөмхий
2. Идсэн хоолны хэмжээнээс хамаарч туурна
3. Загатнана
4. Үе мөчний тэнийлгэгч гадаргаар туурна.
5. Олон дахин сэдэрдэг.

/203./ ГХБ өвчнийг хүнд хөнгөнөөр нь яаж ангилдаг вэ?

1. Цочмог хөнгөн
2. Ужиг хөнгөн
3. Ужиг хүндэвтэр
4. Ужиг хүнд

5. Cor pulmonium үүссэн

/204./ Шүүдэст эмзэгшлийг сэдээгч нь дараах хоолноос аль нь байж болох вэ?

1. Үнээний сүү
2. Өндөг
3. Гүзээлзгэнэ
4. Шоколад
5. Хиам

/205./ Преднизолон ихээр ууж тарихад гарах гаж нөлөө:

1. Хөөж таргална
2. Нүүр сар хэлбэртэй болох, үсэрхэг болох
3. Яс сийрэгжинэ.
4. Ходоодны шарх үүснэ
5. Батгаших

/206./ Гуурсан хоолойн багтрааны эмнэлзүйн гол шинж:

1. Халуурах
2. Бөгшүүлэн ханиах
3. Хяхтнаа амьсгал
4. Шуугиант амьсгал
5. Чээжээр өвдөх

/207./ Ветта2–хүлээн авуурт сонгомлоор үйлчилдэг эмүүд:

1. Сальбутамол
2. Фенотерол
3. Тербуталин
4. Адреналин
5. Эуфиллин

/208./ Жирэмсний сүүлийн саруудад ураг идэвхтэй, идэвхгүй байдлаар мэдрэгждэг нь дараах хүчин зүйлтэй холбоотой

1. Жирэмсэн эмэгтэйн эрүүл мэнд
2. Эх-ихэс-ургийн тогтолцооны өөрчлөлт
3. Ихэсийн хоригийн нэвчимхий чанар ихтэй
4. Янз бүрийн аллерген, эхийн гаммаглобулин
5. Ургийн хучуур бүрхэвчийн бүтцийн өөрчлөлт

/209./ Харшлын сорилыг ямар үед тавьж болохгүй вэ?

1. Халуурч буй үе
2. Харшлын өвчин ид хөдөлсөн үе
3. Биеэр түгээмэл тууралттай үе
4. Гистамин, лейкотриены эсрэг эм уусан үе
5. ДОХ, сүрьеэ

/210./ Шүүдэст эмзэгшлээс сэргийлэхийн тулд жирэмсний сүүлийн хагаст дараах зүйлийг хэрэглэхгүйг хичээх

1. Зөгийн бал
2. Шоколад
3. Өндөг
4. Хоол амтлагч-халуун ногоо
5. Амьтны уураг ихээр

/211./ Хөхүүл хүүхдийн шүүдэст эмзэгшилд өртөх нь:

1. Гистаминаза ферментийн идэвхи сул
2. Ийлдэсний бэхлэх чадвар дорой
3. Карбоксиполипептидаза, моноаминоксидаза, холинэстеразагийн идэвх буурсан
4. Эдүүд нь гистаминд өндөр мэдрэг
5. Хөөнгө эсээс их хэмжээний гистамин чөлөөлөх чадвартай

/212./ Атопийн дерматитын туслах шинжүүд:

1. Удамдаа болон өөрөө харшлын өвчтэй
2. Хоолны харшилтай байх
3. Дермографизм нь цагаан
4. Цусанд IgE өндөр байх

5. Цусанд эозинофиль ихсэх
- /213./ Дараах зүйлсээс аль нь анафилаксийн шок үүсгэх чадвартай вэ?
1. Пенициллин
 2. Рентген тодосгогч бодис
 3. Инсулин
 4. Новокайн
 5. Урьдчилан сэргийлэх тарилга
- /214./ Суулгалттай хүүхдийг хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлөх вэ?
1. Халуурах
 2. Уухдаа муу болох
 3. Баас цустай болох
 4. Бие нь муудах
 5. Хөлрөх
- /215./ Атопийн дерматитын тууралтын онцлог:
1. Загатнаа ихтэй
 2. Нас насанд өөр өөр байрлалтай байх
 3. Халдварт өртөмхий
 4. Олон дахин сэдэрдэг
 5. Гэнэт туурч гэнэт алга болдог
- /216./ Шүүдэст эмзэгшилтэй хүүхдийн бодисын солилцооны онцлог:
1. Ус-давсны солилцоо тогтворгүй
 2. Ус, натрийг барих хандлагатайгаас хүүхэд хөөнгө, илүү жинтэй байна.
 3. Өвчний үед шингэн алдах нь хялбархан, жингээ хурдан алддаг.
 4. Элэгний үйл хямралаас бодисын солилцооны хүчилшил үүсэх хандлагатай
 5. Цусанд уураг багасах, чихэр, тослог ихсэх, аминдэм болон төмөр зэрэг бичил язгуурын дутагдалд өртөмхий
- /217./ Шүүдэст эмзэгшилтэй болох анхны шинжүүд юу вэ?
1. Жин ихтэй төрөх
 2. Зулайд зузаан хаг тогтох
 3. Арьсны нугалаасаар нурах
 4. Халууцахад хацар улайх
 5. Өтгөн тогтворгүй байх
- /218./ Гуурсан хоолойн багтраа өвчнийг дараах өвчнүүдийн алинаас нь ялган оношилох хэрэгтэй вэ?
1. Сүрьеэ
 2. Уушгинд гаднын биет орох
 3. Гуурсанцрын үрэвсэл
 4. Муковисцидоз
 5. Зүрхний багтраа
- /219./ Атопийн дерматитыг сэдээгч хүчин зүйлсийг нэрлэ
1. Хоол хүнс
 2. Амьсгалын замаар ордог харшилтөрөгчид
 3. Нян
 4. Стресс
 5. Цаг уурын нөлөө
- /220./ Цусархаг эмзэгшлийн үед ямар шинж илрэх вэ?
- A. Цусны даралт ихэснэ
 - B. фибриноген багасна
 - C. Тромбоцитын тоо цөөрнө
 - D. Цус урсах хугацаа хэвийн буюу бага зэрэг ихсэх
 - E. Цусны бүлэгнэлт удааширна
- /221./ Хурц явцтай тромбоцитопени хэдэн сар үргэлжилдэг вэ?
- A. 1 жил
 - B. 3 сар
 - C. 6 сар
 - D. 1 сар

Е. 2 жил

/222./ Лейкоз өвчний намжих үеийн шинж тэмдгийг заана уу?

А. Цусархаг хамшинж, ясны хэмд бласт 5%

В. Захын цусанд өөрчлөлтгүй, ясны хэмд бласт 8%, лимфоцит 30%

С. Дэлүү том, захын цусанд бласт 1-2%

Д. Захын цусны үзүүлэлт хэвийн, ясны хэмд бласт 5%, лимфоцит 20%

Е. Эмнэлзүйн өөрчлөлтгүй, захын цусны үзүүлэлт хэвийн, ясны хэмд бласт 8-10%

/223./ Шенлейн-Хенохын өвчнөөр өвчилсөн хүүхдийг хэдэн жил диспансерийн хяналтанд байлгах вэ?

А. 6 сар

В. 1 жил

С. 1-3 жил

Д. 5 жил

Е. 10 жил

/224./ Төлжилтгүйдлийн цус багадалт (гипо, апластик)-ын үед эритроцитын амьдрах хугацаа яаж өөрчлөгдөх вэ?

А. Бараг 2 дахин багасна

В. 4 дахин багасна

С. Өөрчлөгдөхгүй

Д. Бараг 3 дахин богиносно

Е. 1.5 дахин уртасна

/225./ Төлжилтгүйдлийн цус багадалтын үед ямар дүрст элементийн төлжилт багасах вэ?

А. Улаан эс

В. Цагаан эс

С. Ялтсан эс

Д. Тунгалаг эс

Е. Саармаг эс

/226./ Шенлейн-Хенохын өвчний үед дараах шинжүүдээс аль нь илрэхгүй вэ?

А. Арьсаар цусархаг тууралт гарна

В. Үеэр өвдөх

С. Бүх биеэр өвдөх

Д. Гэдсээр өвдөх

Е. Цустай шээх

/227./ Ялтас эсийн үйл хямрах үед үүсэх эмнэлзүйн хамгийн түгээмэл илрэл

А. Цустай шээх

В. Үенд цус хурах

С. Ходоод-гэдэснээс цус алдах

Д. Салстаас цус алдах, арьсаар цусархаг тууралт гарах

Е. Тархи, уушги, элэгнээс аяндаа цус алдах

/228./ Цусархаг эмзэгшлийн үед преднизолоныг дунджаар ямар тунгаар хэрэглэх вэ?

А. 1-2 мг/кг

В. 5-7 мг/кг

С. 10-15 мг/кг

Д. 15 мг/кг

Е. 20 мг/кг

/229./ Шенлейн-Хенохын өвчинд ямар насны хүүхдүүд илүү өртөмтгий вэ?

А. 0-1 нас

В. 2-8 нас

С. 8-10 нас

Д. 10-12 нас

Е. 12-15 нас

/230./ Төмөр дутлын цус дутагдлын үед дараах эмчилгээнүүдээс аль нь онц шаардлагагүй вэ

А. Төмрийн бэлдмэл

В. С-аминдэм

С. В12-аминдэм

Д. Зэсийн бэлдмэл

Е. Хоол эмчилгээ

/231./ Цусархаг эмзэгшлийн үед хэвтрийн дэглэм хэд хоног баримтлах вэ?

- A. 3-5 хоног
- B. 5-7 хоног
- C. 7-10 хоног
- D. 10-14 хоног
- E. 1 сар

/232./ Цочмог лейкоз өвчний оношийг батлах гол шинжилгээг заа

- A. Захын цусанд залуу эс тоолох
- B. Дархлалын эсүүдийг тоолох
- C. Миелограммын шинжилгээ
- D. Цитохимийн шинжилгээ
- E. Цусны биохимийн шинжилгээ

/233./ Аль нь Верльгофын өвчний шинж биш вэ?

- A. Хамраас цус гоожих
- B. Тромбоцитын тоо цөөрөх
- C. Захын цусанд бласт эс илрэх
- D. Цус гоожих хугацаа уртсах
- E. Ретракц муу үүсэх

/234./ Төмрийн бэлдмэлийн эмчилгээний тун ямар байх вэ?

- A. 0.5-1 мг/кг
- B. 2-3 мг/кг
- C. 4.5-6 мг/кг
- D. 8-10 мг/кг
- E. 12-15 мг/кг

/235./ Ходоодны шүүрэл багасгах нөлөөгүй эм:

- A. Викалин
- B. Де-нол
- C. Гастрофарм
- D. Алмагель
- E. Фосфолюгель

/236./ Өсвөр насныханд тохиолдох шархлаа (шарх) хамгийн олонтаа байрлах газар нь:

- A. Ходоодны их махир
- B. Ходоодны бага махир
- C. Ходоодны антрал хэсэг
- D. Дээд гэдэсний булцуу
- E. Булцууны дараах хэсэгт

/237./ В төлөвлөгөөгөөр эмчилж буй хүүхэд ууж чадах болмогц ямар шингэнийг ямар тунгаар уулгах вэ?

- A. Физиологийн уусмал 10 мл/кг-д тооцон уулгах
- B. Буцалсан ус хүссэнээр нь уулгах
- C. ШСД-ны уусмал 10 мл/кг-аар цагт тооцож уулгах
- D. ШСД-ны уусмал 5 мл/кг/цагт тооцож уулгах
- E. Мойлны шүүс 5 мл/кг/хоногт тооцож уулгах

/238./ Эрүүл хүүхдийн арьсны хуниас ямар хугацаанд арилах вэ?

- A. 2 минутын дотор
- B. 1 минутын дотор
- C. 1 секунд хүрэхгүй
- D. 2 секундын дараа
- E. 3 секундын дараа

/239./ Гүш хорхой хаана бие гүйцдэг вэ?

- A. Хөрсөнд
- B. Цусанд
- C. Нарийн гэдэс
- D. Элгэнд
- E. Тахир гэдсэнд

/240./ ХБЗ-ын архаг өвчтэй өсвөр үеийнхнийг эмчийн хяналтанд байлгах хамгийн бага хугацаа:

- A. 6 сар
- B. 1 жил
- C. 2 жил
- D. 3 жил
- E. 4 жил

/241./ Улаан хоолойн архаг үрэвслийн эмчилгээнд үл хэрэглэх эмчилгээ

- A. Хоол эмчилгээ
- B. Хүчлийн эсрэг эм
- C. Холиноспазмолитикүүд
- D. Метоклопрамид
- E. Мотилум

/242./ Шархлаа өвчнийг оношилсон эхний жилд хүүхдийг тогтмол үзэх наад захын хугацаа:

- A. Сар бүр
- B. Гурван сард нэг удаа
- C. Зургаан сард нэг удаа
- D. Жилд нэг удаа
- E. Үзэх шаардлагагүй

/243./ Шархлаа өвчний шалтгаан, нөлөөлөх зүйлд холбогдолгүй нь:

- A. Сэтгэл санааны стресс
- B. Хөнөөх хүчин зүйлийн ихсэлт
- C. Салстын ердийн тэсвэрлэх чадвар сулрах
- D. Хеликобактери
- E. Үнээний сүүний уураг үл шингэх эмгэг

/244./ Хүүхдийн төрөх үеийн жин 3000 грамм, өндөр 52 см байсан бол

- A. Хэвийн
- B. Тураал 1-р зэрэг
- C. Тураал 2-р зэрэг
- D. Тураал 3-р зэрэг
- E. Цус багадалт

/245./ Архаг В-гастрит үүсэхэд холбогдолгүй шалтгаан

- A. Элэгний вирүст үрэвсэл
- B. Салстын нөхөн төлжилт хямрах
- C. Нугалуурын салстад Н.р үржих
- D. Үрэвслийн эсрэг эм удаан уух
- E. Дээд гэдэс, ходоодны сөрөг урсгал

/246./ Ходоодны эмгэгийг илрүүлэхэд хамгийн үр дүнтэй шинжилгээ:

- A. Ходоод хаймсуурдах хэсэгчилсэн шинжилгээ
- B. Ходоодны доторх рН тодорхойлох
- C. Чанд авиан шинжилгээ
- D. Тодосгогчтой рентген шинжилгээ
- E. Уян дурангийн шинжилгээ

/247./ Аюулхай орчмын өвдөлттэй холбоогүй өвчин

- A. Архаг гастрит
- B. Архаг гастродуоденит
- C. Цөсний үйл хямрал
- D. Нойр булчирхайн үрэвсэл
- E. Бүдүүн гэдэсний архаг үрэвсэл

/248./ Шарх булцуунд байрлаж байгаа үед илрэх өвөрмөц бус шинж:

- A. Өлөн элгэн дээр өвдөлт их
- B. 1.5-2 цагийн дараа дахин өвдөх
- C. Гашуун юмаар хэхрэх
- D. Дотор хорсох
- E. Өглөөгүүр огиулах

/249./ Гүш хорхойн авгалдай нүүдэллэх шатандаа хаана байрлах вэ?

- A. Нарийн гэдэс (НГ)-ний эхлэх хэсэгт
- B. НГ-ний төгсгөлд
- C. Бүдүүн гэдэсний эхэн хэсэгт
- D. Тахир гэдсэнд
- E. Уушгинд

/250./ 1-15 хүртэлх насны хүүхдийн үүдэн шүднээс ходоодны амсар хүртэлх хэмжээг олох
Н.Гэндэнжамцын томъёо аль нь вэ? * X- 1-15 хүртэлх насны хүүхдийн үүдэн шүднээс ходоодны амсар хүртэлх зай, n- Хүүхдийн насалсан жил

- A. $X=15+(n-1)$
- B. $X=18+(n-1)$
- C. $X=20+(n-1)$
- D. $X=22+(n-1)$
- E. $X=25+(n-1)$

/251./ Анхдагч гастрит үүсэхэд хамгийн их нөлөөтэй нь:

- A. Эм байнга уух
- B. Хооллолтын хүчин зүйл
- C. Гэдэсний халдвараар өвчлөх
- D. Эрт унтах
- E. Чихэр их идэх

/252./ Эссенциал ямар үйлчилгээтэй вэ?

- A. Хепатоцитын сарьс бэхжүүлэх, элэгний эсийг төлжүүлэх
- B. Элэгний эсийн тэжээлийг сайжруулах
- C. Мезенхимийн урвалыг саатуулах
- D. Цөс хөөх
- E. Аутоиммун урвалыг дарих

/253./ Улаан хоолойн үрэвслийг илтгэх хамгийн чухал шинж

- A. Идсэн ууснаараа бөөлжих
- B. Огиулах
- C. Зогисуулах
- D. Өвчүүний араар өвдөх
- E. Турах

/254./ Гүш хорхойн байрладаг, өндөглөдөг газар:

- A. Дээд гэдэс
- B. Цөсний суваг
- C. Нарийн гэдэс
- D. Бүдүүн гэдэс
- E. Уушги

/255./ Гастродуоденитийн үе дэх өвдөлтийн байрлалыг заа

- A. Аюулхай дор
- B. Баруун сүврэгдэс
- C. Зүүн сүврэгдэс
- D. Хүйсний хавьд
- E. Нугалуур, дээд гэдэсний бүсэд

/256./ Шархлаа өвчний хүндрэлүүдээс аль нь мэс заслын яаралтай эмчилгээ шаардахгүй вэ?

- A. Цус алдалт (их)
- B. Шарх цоорох
- C. Нугалуурын нарийсалт
- D. Перивисцерит
- E. Пенетраци

/257./ Улаан хоолой үрэвсэхэд аль нь хамгийн их нөлөөтэй вэ?

- A. Ходоодны шүүрэл хэт ихсэх
- B. Хурц хоол их идэх
- C. Удамшил
- D. Сэтгэл санааны стресс
- E. Ходоод-улаан хоолойн сөрөг урсгал

/258./ Гастродуоденитийн үеийн хүчтэй өвдөлтийг намжаах физик эмчилгээнд хэрэглэх арга, бодис

- A. Цахилгаан унтуулга
- B. Хаалганы бүсэд новокайнтай электрофорез
- C. Хэвлийн дээд хэсэгт диатерми
- D. Нугалуур дээд гэдэсний бүсэд новокайнтай электрофорез
- E. УВЧ эмчилгээ

/259./ Ходоод-улаан хоолойн сөрөг урсгалыг багасгах нь

- A. Но-шпа
- B. Атропин
- C. Папаверин
- D. Церукал
- E. Анестезин

/260./ Ходоод-улаан хоолойн сөрөг урсгал, улаан хоолойн архаг үрэвслээр хүндэрсэн үед өвчтөнд хориглохгүй зүйл:

- A. Хүнд юм өргөх
- B. Тонгойж, бөхийх дасгал хийх
- C. Бүсээ чанга бүслэх
- D. Унтахынхаа өмнөхөн хоол идэх
- E. Өглөө эрүүл ахуйн гимнастик хийх

/261./ Архаг гастрит оношлогдсон анхны жилд хүүхдийг үзлэгт оруулах хугацаа:

- A. Сар бүр
- B. 3 сард нэг удаа
- C. 6 сард нэг удаа
- D. Жилд нэг удаа
- E. 2 жилд нэг удаа

/262./ Аюулхай дор өвдөлттэй үед чанд авианы шинжилгээ, оношилгооны ач холбогдол бага өвчин:

- A. Цэсний хүүдийн хөдөлгөөний хямрал
- B. Цэс чулуужих өвчин
- C. Шархлаа өвчин
- D. Архаг гепатит
- E. Цочмог панкреатит

/263./ Шархлаа өвчний рентген шинжилгээнд шууд илрэх шинж:

- A. Дээд гэдэсний хөдөлгөөн түргэсэх
- B. Шүүрэл ихсэх
- C. Ходоодноос тодосгогч бодис түргэн гарах, хоосрох
- D. Шарх “Ниша” харагдах
- E. Булцуунд зогсонгиших

/264./ Шархлаа өвчин үүсэхэд эмгэг жамын хамгийн их ач холбогдолтой нь:

- A. Сэтгэл санааны ачаалал
- B. Хоолны дэглэм алдагдах
- C. Дисбактериоз
- D. Харшлах байдал
- E. Салстын тэсвэрлэх чадвар буурах

/265./ Хэдэн хоног суулгасан бол ужиг суулгалт гэж үнэлэх вэ?

- A. 7 хоног
- B. 10 хоног
- C. 12 хоног
- D. 14 хоног хүртэл
- E. 14 хоног буюу түүнээс дээш

/266./ Аль үеийг сурган хүмүүжүүлэгчид хүүхэд хүмүүжүүлэх хамгийн чухал үе гэж үздэг вэ?

- A. Хөхүүл үе
- B. Сургуулийн өмнөх насны урьдал үе
- C. Сургуулийн насны өмнөх үе
- D. Бага сургуулийн үе

- Е. Дунд сургуулийн үе
- /267./ 6 сар хүртэлх насны хүүхдийн жин хоногт хэдэн грамм нэмэгдэж байвал тураалд орохгүй вэ?
- А. 5.0 г
 - В. 10.0 г
 - С. 15.0 г
 - Д. 20.0 г
 - Е. 25-30.0 г
- /268./ Ходоод угааж болохгүй заалт
- А. Угаадастай хамт цус гарах
 - В. ХБЗ-ын химийн түлэгдэлт
 - С. Ухаангүй байдал
 - Д. Зүрхний шигдээс
 - Е. Эсрэг заалт байхгүй
- /269./ Элэгний архаг үрэвсэлтэй хүүхэд дараах хоолноос хамгийн тохиромжтойг заа
- А. Сүүтэй будаа
 - В. Цөцгийтэй тараг
 - С. Ээдэм, бяслаг
 - Д. Үхрийн мах
 - Е. Тахианы мах
- /270./ Бүдүүн гэдэсний нянгийн хэдэн хувь нь агааргүйтэн бэ?
- А. 0.3
 - В. 0.7
 - С. 0.8
 - Д. 85-89%
 - Е. 96-99%
- /271./ Хепатоцитын цитоплазмын сарьс гэмтэхэд ямар фермент ихсэх вэ?
- А. Хүчиллэг фосфатаза
 - В. Алат, Асат
 - С. Шүлтлэг фосфатаза
 - Д. Урокиназа
 - Е. Нуклеаза
- /272./ Бага насны хүүхдэд пиелонефрит ямар эмнэлзүйн шинжээр илрэх вэ?
- 1. Халуурах
 - 2. Ойр, ойрхон шээх
 - 3. Хоолонд муудах
 - 4. Уцаарлах
 - 5. Шээхэд өвдөх
- /273./ Эхийн IgG нярай үед юунаас хамгаалахгүй вэ?
- 1. Сахуугийн хор
 - 2. Саа
 - 3. Улаан бурхан
 - 4. E.coli
 - 5. Улаанууд
- /274./ Нярайн ДТ – ны онцлогуудыг заа?
- 1. С' ялангуяа С'З үлэмж бага
 - 2. Цитокин, интерфероны ялгаралт сааталтай
 - 3. Залгиур эсийн ойртох, боловсруулах үйл дутмаг
 - 4. Лимфоцит, нейтрофилийн анхдагч зөрлөг эхэлдэг
 - 5. Нярайн дархлаа тогтолцоо дарангуйлагдсан чиглэлтэй
- /275./ 4 -6 сартай хүүхдийн ДТ – ны онцлогийг заа?
- 1. Эхээс авсан идэвхгүй дархлаа суларна
 - 2. Дархлаа урвалын супрессор чиглэл хэвээр
 - 3. RS, иж томуу, аденовирүст маш өртөмтгий
 - 4. Хэсэг газрын дархлаа сул
 - 5. Олонх АГ-нд анхдагч дархлаа хариулт давамгайлах тул дархлаа дурсамж үүсэхгүй

/276./ Хоёрдогч дархлаа дутал (ХДД)-ын үндсэн шалтгаан юу вэ?

1. Халдвар
2. Бөөрний архаг дутал (БАД)
3. Мэс засал мэдээгүйжүүлэлт
4. Глюкокортикоид, цитостатик эмүүд
5. Зүрхний төрөлхийн хавсарсан гажиг

/277./ Хоёрдогч дархлаа дутлын гол шалтгааныг заа?

1. Туяа эмчилгээ
2. Хавдрын эсрэг бэлдмэлүүд
3. Иммуноглобулинээ (гэдэс, бөөрөөр) алдах
4. Дэлүүгээ авахуулах
5. Виүсийн халдвараар өвчлөх

/278./ Аль нь хүүхдийн ДТ-ны физиологийн сулралын үе биш вэ?

1. Нярай үе
2. 4-6 сар
3. 2 нас
4. 3 нас
5. 4-6 нас

/279./ Анхдагч дархлаа дутал (АДД)-ын эмгэгээс аль нь хамгийн элбэг вэ? (Н.П.Шабаловын бичсэнээр)

1. Брутоны өвчин
2. Хавсармал ДД
3. Залгиур эсийн согог
4. IgA-гийн сонгомол дутал
5. Хавсаргын согог

/280./ Эх-ихэс-ургаас ялгардаг дархлаа дарангуйлагч хүчин зүйлийг заа?

1. Трофобластын дарангуйлагч хүчин
2. $\alpha 1$ -фетопротейн
3. Хорионы гонадотропин
4. Прогестрон,
5. ПГЕ-ийн нийлэгжил ихсэх

/281./ Нярайн дархлаа тогтолцооны онцлогийг заа?

1. Грам (-), идээрлүүлэгч, нөхцөлт эмгэгтөрөгч нянд эсэргүүцэл сул
2. Халдвар түргэн түгэх, үжих хандлага өндөр
3. Эсийн АТ – ээр хамгаалагдаагүй вирүсийн халдварт өндөр өртөмтгий
4. IgG сайн нийлэгжүүлдэг
5. Халдварын эсрэг хоёрдогч дархлаа хариултаар хариулна

/282./ Өсвөр үеийн ДТ-ны онцлогийг заа?

1. Сүрьеэгийн нянд мэдрэгжил ихэснэ
2. ДТ-нд гадаад хүчний нөлөө өснө
3. Бэлгийн дааврын ялгаралт идэвхжиж эсийн дархлаа дарангуйлагдана
4. Хэсэг газрын дархлаа сул
5. Аутоиммун (өөсөө дархлаа) өвчинд тэсвэртэй

/283./ Урагийн 23 хромосом эцгээс ирэх ба энэ нь эхийн ДТ-нд харийн шинжтэй ч эхийн ДТ үрийнхээ АГ-ийг тэвчдэг.

/284./ Дархлаа эмчилгээ нь ДТ дарангуйлагдсан бол сэргээх, ихэссэн бол дарангуйлах, дутагдсан үед нөхөх зорилготой.

/285./ Цочмог ГН-ийн үед эмнэлзүйд давамгайлан илрэх эмнэлзүйн хамшинжийг сонгоно уу

1. Нефроз хамшинж
2. Нефрит хамшинж
3. Холимог хамшинж
4. АД ихсэх хамшинж
5. Өвдөлтийн хамшинж

/286./ Цочмог ГН-ийн хэдэн хувьд макрогематури илрэх вэ?

1. 10
2. 30

3. 40
4. 50
5. 100

/287./ Глюкокортикойд эмчилгээний гаж нөлөө юу вэ?

1. Иценго-Кушингийн хамшинж
2. Артерийн даралт ихдэх
3. Остеопороз
4. Гипергликеми
5. Хоёрдогч халдвар үүсэх

/288./ Пиелонефритийн үед ямар үйлчилгээтэй антибиотикийг сонгох вэ?

1. Грам эерэг нянгийн эсрэг
2. Бактерцид
3. Грам сөрөг нянгийн эсрэг
4. Өргөн хүрээний үйлчилгээтэй
5. Бактериостатик үйлчилгээтэй

/289./ Охидын шээсний сувгийн онцлог нь:

1. Шээсний суваг өргөн
2. Маш богинохон
3. Уян, холбогч эдийн хөгжил дутмаг
4. Булчингийн ширхэг сайн хөгжсөн
5. 3-6 см урт байдаг

/290./ Цочмог гломерулонефритийн үед эмнэлзүйд гарах шинжүүд.

1. Шээс цустах, бортгонцортох
2. Шээсний гарц багасах
3. Шээсний нягт хэвийн эсвэл ихсэх
4. Шээсний нягт багасах
5. Шээсний гарц ихсэх

/291./ Цочмог ГН-ийн үед өвчтнийг хагас хэвтрийн дэглэмд шилжүүлэх заалт

1. Артерийн даралт хэвийн
2. Хавангүй
3. СОЭ хэвийн
4. Шээсний ерөнхий шинжилгээнд уураг 1% хүртэл буурсан
5. Улаан эсийн тоо цөөрсөн (30-40 х/т)

/292./ Бага насны хүүхдэд бөөр-шээсний замын халдвар үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл:

1. Энтеробиоз
2. Гаж хөгжил
3. Давсагны үйл ажиллагаа алдагдах
4. Баасан дээрээ удаан хэвтэх
5. Хөвгүүдийн тээрхийн нарийсал

/293./ Шалтгаан тодорхойгүй удаан халуурсан хүүхдэд хамгийн түрүүнд ямар шинжилгээ хийх вэ?

1. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
2. Шээсний ерөнхий шинжилгээ
3. Ц-урвалжит уураг
4. Биохимийн шинжилгээ
5. Коагулограмма

/294./ 3 хүртэлх насны хүүхдэд шээс дамжуулах замын халдварын өвөрмөц шинж илэрвэл ямар арга хэмжээ авах вэ?

1. Шээсний ерөнхий шинжилгээ
2. Шээсэнд нян ургуулах
3. Антибиотик эмчилгээг шууд эхлэх
4. Биохимийн шинжилгээ
5. Цистографийн шинжилгээ

/295./ 3 настай охин халуурсан, ойр ойрхон шээнэ, шээхэд өвдөнө гэсэн зовууртай эмчид ханджээ. Нэн шаардлагатай шинжилгээнүүдийг сонгоно уу.

1. ШЕШ

2. Шээсэнд нян ургуулах
3. Хэвлийн ЭХО
4. Цусны ерөнхий шинжилгээ
5. Биохими

/296./ Цочмог гломерулонефритийг бөөрний үйл ажиллагааны байдлаар нь хэрхэн ангилдаг вэ?

1. Бөөрний үйл алдагдаагүй
2. Бөөрний үйл алдагдсан
3. Бөөрний цочмог дутагдал
4. Бөөрний үйл бага зэрэг алдагдсан
5. Бөөрний архаг дутагдал

/297./ Архаг ГН нь

1. Хүнд явцтай
2. Эмнэлзүйн хувьд дахидаг
3. Бөөрний дутагдалд амархан ордог
4. Бүтцийн эргэшгүй өөрчлөлтөнд ордог
5. Зөвхөн анхдагч өвчний үед илэрнэ

/298./ Цочмог ГН-ийн үед шээсний талаас ямар өөрчлөлтүүд гарах вэ?

1. Олигоури
2. Гематури
3. Протеинури
4. Пиури
5. Шээсний нягт багасна

/299./ Шээс дамжуулах доод замын халдварт аль нь орох вэ?

1. Пиелонефрит
2. Уретрит
3. Гломерулонефрит
4. Цистит
5. Тубулопати

/300./ Архаг ГН-ийн шалтгаанд аль нь орох вэ?

1. Бөөрөнд халтай эм
2. Үрэвслийн эсрэг стеройд бус эмийг удаан хэрэглэх
3. Халдварын архаг голомт
4. Вирусийн халдвар
5. Ахуйн таагүй байдал

/301./ Хүүхдийн шээлэйн онцлог нь :

1. Харьцангуй өргөн
2. 0.3 - 0.4 см зузаан ханатай
3. Нугалаа ихтэй
4. Булчингийн ширхэг сул хөгжсөн
5. Уян эд сул хөгжсөн

/302./ ГН-ийн үед үүсэх хавангийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлс

1. Шээсээр ялгарах уургийн хэмжээ
2. Ууж байгаа шингэний хэмжээ
3. Түүдгэнцрийн шүүрлийн хэмжээ
4. Цусны кальци багасах
5. Уургийн онкос даралт өөрчлөгдөхгүй байх

/303./ Суларсан амьсгал ямар эмгэгүүдийн үед сонсогдох вэ?

1. Уушгинд авчилз үүсэх
2. Уушгины эд хатуурах
3. Чээжний гялтан хөндийд хий, шингэн хуралдах
4. Гялтан хальс зузаарах
5. Төвөнхийн нарийсал

/304./ Цочмог гломерулонефритийн үед хийх эмчилгээний зарчмыг сонгоно уу

1. Хоол, хөдөлгөөний дэглэм сахих
2. Бактерийн эсрэг эмчилгээ

3. Шинж тэмдгийн эмчилгээ
4. Эмгэг жамын эмчилгээ
5. Иммунодепрессант эмчилгээ

/305./ Бөөр-шээсний замын халдвартай хүүхдэд илэрч болох өөрчлөлтүүдийг сонгоно уу?

1. Лейкоцитоз, саармагсаг эс багасах, лимфоцитоз
2. Пиури, шээсэнд нитрит эерэг байх
3. Шээсэнд эмгэгтөрөгч 5000 илрэх
4. Лейкоцитоз, саармагсаг эс ихсэх
5. Аддисын сорилд лейкоцит 1 сая

/306./ Архаг ГН-ийг ямар өвчнүүдээс ялган оношлох вэ?

1. Архаг пиелонефрит
2. Шээс чулуужих өвчин
3. Удамшлын нефрит
4. Бөөрний судасны эмгэг
5. Эмийн эмчилгээний хүндрэл

/307./ Цочмог гломерулонефритийг үе шатаар хэрхэн ангилдаг вэ?

1. Эхний илрэл
2. Эдгэрэх
3. Архагт шилжих
4. Хагас намжилт
5. Эмнэлзүй, лабораторийн бүрэн намжилт

/308./ Шээсний ерөнхий шинжилгээнд мөхлөгт бортгонцор, гиалин бортгонцор нь юуг илэрхийлэх вэ?

1. Түүдгэнцрийн эмгэгүүдийг илэрхийлнэ
2. Шээсэнд уураг ялгарч буйг илэрхийлнэ
3. Шээсэнд улаан эс гарч байгааг илэрхийлнэ
4. Сувганцрын эмгэгийг илэрхийлнэ
5. Шээсэнд нян байгааг илэрхийлнэ

/309./ Цочмог гломерулонефритийн үед хавагнаж байгаа шалтгаан

1. Цус, шээс ба эдийн эрдсийн бүрэлдэхүүн хямрах
2. Хялгасан судасны эзлэхүүн өөрчлөгдөх
3. Цусны уураг багассанаас сийвэнгийн онкотик даралт хямрах
4. Түүдгэнцрийн шүүрэлтийн хурд нэмэгдсэнээс
5. Сувганцрын эргэн шимэгдэлт буурснаас

/310./ Аль нь бөөр-шээсний замын өвчин үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл биш вэ?

1. Биеийн ерөнхий ба хэсэг газрын эсэргүүцэл сул
2. Хүүхэд голдуу илүү тээлттэй байх
3. Бөөрний эдийн хөгжил бүрэн гүйцээгүй
4. Жирэмсэн үеийн ургийн хөдөлгөөний идэвх сул байх
5. Шээсний урсгалын төрөлхийн ба олдмол саад

/311./ Цочмог ГН-ийн хүндрэл

1. Бөөрний эклампси
2. Бөөрний цочмог дутагдал
3. Зүүн ховдлын цочмог дутагдал
4. Бөөрний архаг дутагдал
5. Гиповолемийн шок

/312./ Пиелонефритийн үндсэн хамшинжид аль нь орох вэ?

1. Өвдөлтийн хамшинж
2. Дизурийн хамшинж
3. Хордлогын хамшинж
4. Цусархагшлын хамшинж
5. Хавагнах хамшинж

/313./ Пиелонефритийн үед хэрэглэх антибиотикийн зөв тунг сонгоно уу?

1. Цефотаксим 75-100 мг/кг
2. Гентамицин 2-7.5 мг/кг
3. Ампициллин 50-150 мг/кг

4. Левофлоксацин 250-500 мг/кг

5. Ципринол 200-400 мг/кг

/314./ 13 настай хүүхдийн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?

A. 242 мг

B. 122 мг

C. 400 мг

D. 600 мг

E. 2600 мг

/315./ Төмөр дутлын цус багадалтын үед сийвэнгийн төмөр сэлбэх чадвар хэдээс дээш болох вэ?

A. 23 мкмоль/л

B. 43 мкмоль/л

C. 53 мкмоль/л

D. 63 мкмоль/л

E. 83 мкмоль/л

/316./ Төмөр дутлын цус багадалтын үед 6 хүртэлх насны хүүхдэд Hb хэмжээ хэдээс доош байх вэ?

A. 100 г/л

B. 110 г/л

C. 120 г/л

D. 130 г/л

E. 140 г/л

/317./ Тураалын II зэргийн үед жингийн алдагдал ямар байх вэ?

A. 10-15%

B. 21-30%

C. 11-20%

D. 30-40%

E. 40-45%

/318./ Хүнд тураалтай хүүхдийн хоолонд аль нь илүү тохирох вэ?

A. Үнээний сүү

B. Шингэн бантан

C. Хярам

D. Хөхний сүү

E. Өтгөн зутан

/319./ 5 настай хүүхдийн гемоглобинд агуулагдах төмөр нийт төмрийн хэдэн хувийг эзлэх вэ?

A. 55

B. 70

C. 72

D. 73

E. 79

/320./ 1 настай хүүхдийн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?

A. 242 мг

B. 122 мг

C. 400 мг

D. 600 мг

E. 2600 мг

/321./ Төмөр дутлын цус багадалтын үед сийвэнгийн төмрийн хэмжээ хэдээс доош байх вэ?

A. 4 мкмоль/л

B. 14 мкмоль/л

C. 24 мкмоль/л

D. 34 мкмоль/л

E. 10 мкмоль/л

/322./ Тураалын II зэргийн үед арьсан доорх өөхөн эд хэрхэн өөрчлөгдөх вэ?

A. Нүүрнээс бусад хэсэгт нимгэрсэн байна

B. Хэвлий, чээжинд арилж, мөчдөөр эрс багассан

C. Бүх биеийн өөхөн давхарга арилна

D. Нүүр, мөчдөөр нимгэрч, бусад хэсэгт хэвийн байна

E. Нүүрэнд арилж, хэвлий чээжинд нимгэрсэн

/323./ Тураалтай нэгээс дээш насны хүүхдэд өгөх А-аминдэмийн нэг удаагийн тун ямар байх вэ?

A. 10000 ME

B. 50000 ME

C. 100000 ME

D. 200000 ME

E. 300000 ME

/324./ Хүнд тураалтай хүүхдэд хоногт нэмж өгөх магнийн хэмжээ хэд вэ?

A. 0.4-0.6 ммоль/кг

B. 1.0-2.0 ммоль/кг

C. 3.0-4.0 ммоль/кг

D. 5.0-6.0 ммоль/кг

E. 7.0-8.0 ммоль/кг

/325./ Тураалын II зэрэгтэй хүүхдийг хэдэн удаа хооллох вэ?

A. 5

B. 6

C. 7

D. 8

E. 9

/326./ Рахитын эхлэл үед хүүхдэд өгөх D-аминдэмийн тун ямар байх вэ?

A. 500-600 ME/хоног

B. 100-200 ME/кг

C. 2000-5000 ME/хоног

D. 200000-400000 ME/курс

E. 50-100 ME/кг

/327./ Тураалтай 6 сар хүрээгүй хүүхдэд өгөх А-аминдэмийн нэг удаагийн тун ямар байх вэ?

A. 10000 ME

B. 50000 ME

C. 100000 ME

D. 200000 ME

E. 300000 ME

/328./ Тураалын I зэрэгтэй хүүхдийн хоолны илчлэг хоногт хэд байх вэ?

A. 110-130 ккал/кг

B. 100-95 ккал/кг

C. 90-85 ккал/кг

D. 80-65 ккал/кг

E. 60-50 ккал/кг

/329./ Төмөр дутлын цус багадалтын үед ферритиний хэмжээ хэдээс доош байх вэ?

A. 10 нг/мл

B. 20 нг/мл

C. 30 нг/мл

D. 40 нг/мл

E. 50 нг/мл

/330./ 2 настай хүүхдийн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?

A. 242 мг

B. 122 мг

C. 400 мг

D. 600 мг

E. 2600 мг

/331./ Үнээний сүүг хоногт хэдэн литрээс илүү хэрэглэхэд хүүхдэд төмрийн дутагдал үүсч болох вэ?

A. 0.1

B. 0.5

C. 1

D. 2

E. 3

/332./ Тураалын II зэрэгтэй хүүхдийн хоолны илчлэг хоногт хэд байх вэ?

A. 110-130 ккал/кг

B. 100-95 ккал/кг

C. 90-85 ккал/кг

D. 80-65 ккал/кг

E. 60-50 ккал/кг

/333./ Гүйцэт нярайн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?

A. 242 мг

B. 122 мг

C. 400 мг

D. 600 мг

E. 2600 мг

/334./ Төмөр дутлын цус багадалтын үед улаан эсийн дундаж эзлэхүүн (MCV) хэдээс доош байх вэ?

A. 60 фл

B. 70 фл

C. 80 фл

D. 90 фл

E. 90 фл

/335./ Төмөр дутлын цус багадалтын үед хүүхдэд өгөх төмрийн хэмжээ ямар байх вэ?

A. 0.5-0.8 мг/кг

B. 1-2 мг/кг

C. 3-5 мг/кг

D. 6-8 мг/кг

E. 8-10 мг/кг

/336./ Хоол хүнсэн дэх төмрийн хэдэн хувь нь шимэгддэг вэ?

A. 1

B. 2

C. 10

D. 15

E. 20

/337./ Тураалын III зэрэгтэй хүүхдийн хоолны илчлэг хоногт хэд байх вэ?

A. 110-130 ккал/кг

B. 100-95 ккал/кг

C. 90-85 ккал/кг

D. 80-65 ккал/кг

E. 60-50 ккал/кг

/338./ Амьсгалын дутагдлын IV зэргийн үед илрэх эмнэлзүйн шинж

1. Хүүхэд ухаангүй

2. Амьсгал өнгөц, хэм алдагдах

3. Тархмал хөхрөлт

4. Цусны хүчилтөрөгчийн хангамж 50%-иас буурах

5. Хүчил-суурийн тэнцвэр $pH < 7.15$ болох

/339./ Томуугийн вирүсээр үүсгэгдсэн залгиурын үрэвслийн онцлог шинж

1. Залгиурын арын хана, хүүхэн хэлний уг, зөөлөн тагнайн судсууд өргөсөх

2. Хатуу, зөөлөн тагнай, залгиурын арын хананы салст бүрхэвчинд жижиг, цэгчилсэн цус харвалт гарах

3. Ерөнхий хордлогын шинж тод илрэх

4. Төвөнхийн үрэвсэлтэй хавсарч явагдах

5. 390C-аас өндөр халуурч хоолой хүчтэй өвдөх

/340./ Дууны доргио ямар тохиолдолд сулрах вэ ?

1. Уушгинд авчилз үүсэх

2. Чээжний хөндийд шингэн хуралдах

3. Чээжний гялтангийн хавдар

4. Уушгины эд нягтран хатуурах
 5. Уушгинд хөндий үүсэх
- /341./ Хүнд халдвар, хордлогын үед амьсгалын дутагдал үүсэх шалтгаан
1. Зүрхний булчингийн үрэвсэл
 2. Эсийн эсгэгийн тогтолцоо хямрах
 3. Зүрхний үнхэлцгэн хальсны үрэвсэл
 4. Эд, эс хүчилтөрөгч үл шингээх
 5. Чээжний гялтангийн хөндийд шингэн хуралдах
- /342./ АЦХ-тай хүүхдийг гэрээр асрахдаа анхаарах зүйлс
1. Сайн хооллох
 2. Шингэн их уулгах
 3. Хүүхдийг хэт бэгнэхгүй байх
 4. Хооллохын өмнө хамрыг заавал цэвэрлэх
 5. 6 сар хүрээгүй хөхүүл хүүхдийг тураалаас сэргийлж эрт хоолонд оруулах
- /343./ Аденоидитын үед хүүхдэд илрэх эмнэлзүйн шинж
1. Хамар байнга битүүрэх
 2. Амаа ангайн их хухирч унтах
 3. Доод эрүү унжих
 4. Хамар-уруулын нугалаас арилах
 5. Нүүр хөөнгө цэлхгэр өвөрмөц харагдах
- /344./ Цефалоспорины бүлгийн антибиотик
1. Цефоперазон
 2. Цефотам
 3. Цефотриаксон
 4. Цефатазидим
 5. Цефотаксим
- /345./ Гуурсан хоолойн үрэвслийн онцлог шинж
1. Вирүс, нянгаар хавсарч үүсгэгдэх
 2. Бөглөршилт үрэвслийн үед бөгшүүлж ханиалгах нь илүү
 3. Ихэнх тохиолдолд бусад хамшинжүүдтэй хавсарч илрэх
 4. Өвчний эхний хоногуудад хүүхэд хуурай ширүүн, зовуурьтай бөгшүүлж ханиах
 5. Том хүүхдэд өвчүүний араар сэрвэгнэх, хорсох, халуун оргиж өвдөх
- /346./ Төвөнх мөгөөрсөн хоолойн цочмог нарийсалт үрэвсэл үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл
1. Сульдаа
 2. Шүүдэст гаж байдал
 3. Хөөнгө мариа
 4. Аминдэм дутал
 5. Улирлын байдал
- /347./ Амьсгал гаргах саадтай байдал ямар үед үүсэх вэ ?
1. Гуурсан хоолойн булчин агших
 2. Гуурсан хоолойд цэр хуримтлагдах
 3. Гуурсан хоолойн салс хөөж хавагнах
 4. Гуурсан хоолойн багтрааны үед
 5. Төвөнхийн үрэвсэл
- /348./ Цэр ховхорч буй үед ханиалга намдаах эм хэрэглэхэд гарах өөрчлөлт
1. Өвчний зовуурь багасах
 2. Цэрний гадагшлалт саатах
 3. Үрэвслийн шинж арилах
 4. Гуурсны бөглөршилт гүнзгийрах
 5. Ханиалга багсаж, өвчний эдгэрэлт хурдсах
- /349./ Уушгины хатгалгаагүй ханиад шуухинаа гэж ангилсан 4 сартай хүүхдэд ямар зөвлөгөө өгөх вэ?
1. 30-аас олон хоног ханиалгасан бол онош тодруулахаар эмнэлэгт хэвтүүлэх
 2. Хоргүй зөөлөн эмээр хоолойн өвдөлт, ханиалгыг эмчилэх
 3. Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлөх
 4. Хэрэв сайжрахгүй бол 5 хоноод давтан үзүүлэх

5. А-аминдэм өгөх

/350./ Дараах эмгэгүүдийн алинд нь тогшилтын чимээ өөрчлөгдөх вэ?

1. Гялтанд хий, шингэн хуралдах
2. Уушгинд авчилз үүсэх
3. Кораны шинж
4. Уушгины агааржилт ихсэх
5. Философовын аяганы шинж

/351./ Гүйлсэн булчирхайн архаг үрэвслийн үеийн эмчилгээний ерөнхий зарчим

1. Хүүхдийг чийрэгжүүлэх, аминдэмжүүлэх, сайн хооллох
2. Ерөнхий ба хэсэг газрын дархлаа сулруулах нөлөөллөөс зайлсхийх
3. Үүсгэгчийн эсрэг антибиотик эмчилгээ
4. Хордлого тайлах эмчилгээ
5. Хэсэг газрын эмчилгээ

/352./ Гүйлсэн булчирхайн үрэвслийн үед илрэх эмнэлзүйн шинж

1. Хүүхдийн бие тавгүйцэн хоолой сэрвэгнэж торох
2. Өндөр халуурч өвчин цочмог эхлэх
3. Шүлс залгих, юм идэж уухад өвдөлт нэмэгдэх
4. Заримдаа булчингууд болон үеэр өвдөх
5. Эрүүн доорх болон хүзүүний арын булчирхай томорч хөндүүрлэх

/353./ Хуурай исгэрсэн хэржигнүүр ямар эмгэгүүдийн үед сонсогдох вэ?

1. Залгиур, мөгөөрсөн хоолойн үрэвсэл
2. Гуурсан хоолойн багтраа
3. Уушгины үрэвсэл
4. Гуурсан хоолойн бөглөршилт үрэвсэл
5. Уушгины нэвчдэст үрэвсэл

/354./ Амьдралын түүхээс тодруулж асуух зүйл

1. Амьсгалын эрхтний эмгэгээр өвчлөхөд нөлөөлөх урьдал хүчин зүйлүүд
2. Хооллолт
3. Амьдарлын нөхцөл, орчны эрүүл ахуй
4. Урьд өвчилсөн халдварт болон халдварт бус өвчин
5. Товлолын дагуу вакцинд хамрагдсан эсэх

/355./ Парацетамолын гаж нөлөө

1. Арьс загатнаж тууралт гарах
2. Нүүр хавагнах, нүүр хөхрөх
3. Цус багадах, цагаан эс цөөрөх
4. Цустай шээх
5. Зүрх, бөөр, элэгний үйл ажиллагаа хямрах

/356./ Ханиалга намдаах бэлдмэлийг үйлчлэх механизмаар нь хэрхэн ангилах вэ?

1. Төвийн үйлдэлтэй
2. Захын үйлдэлтэй
3. Хавсарсан үйлдэлтэй
4. Ханиалга сэдээх
5. Ханиалга дарангуйлах

/357./ Шимэгчийн халдварын үед хэрэглэх эм

1. Хлорамфеникол
2. Амикацин
3. Цефуросин
4. Метранидазол
5. Линкомицин

/358./ Аденовирүсээр үүсгэгдсэн залгиурын үрэвслийн онцлог шинж

1. Хөөмий, хүүхэн хэл, залгиурын арын хана хавагнан хөөх
2. Залгиурын арын хана улаан, бэржгэр болох
3. Хүзүүний арын тунгалгийн булчирхай томрох
4. Гүйлсэн булчирхай хөөж томрох
5. Өвчин дунджаар 2 долоо хоног үргэлжлэх

/359./ Дууны доргио доорх эмгэгүүдийн алинд нь ихсэх вэ ?

1. Чээжний хөндийд хий хуралдах
2. Уушгины эд нягтран хатуурах
3. Уушгинд авчилз үүсэх
4. Уушгинд хөндий үүсэх
5. Чээжний гялтангийн хавдрын үед

/360./ Бактериостатик үйлчилгээтэй антибиотик

1. Тетрациклин
2. Хлорамфеникол
3. Линкомицин
4. Фузидин
5. Аминогликозид

/361./ Мөгөөрсөн хоолойн үрэвслийн үед илрэх эмнэлзүйн шинж

1. 1. Томуугийн халдварын үед ихэвчлэн илрэх
2. Эхний хоногуудад хуурай бөгшүүлж ханиалгах
3. 3. Өвчүүний ард, чээж хорсож, зүсэгдэж буй мэт өвдөх
4. Уушги чагнахад амьсгал ширүүн, хуурай эсвэл том хөөслөг цэврүүт нойтон хэржигнүүр сонсогдох
5. Рентген шинжилгээнд уушгины уг ялимгүй өргөсөх

/362./ Читамоны үйлдэл

1. Цэр ховхлох
2. Тайвшруулах
3. Үрэвсэл намдаах
4. Өвчин намдаах
5. Халуун бууруулах

/363./ Хэдэн нас хүртэлх хүүхдэд байршлын тогшилт хийх боломжгүй вэ?

1. 1 нас
2. 3 нас
3. 5 нас
4. 7 нас
5. 9 нас

/364./ Өвчний түүхээс тодруулж асуух зүйл

1. Өвчин хэдийд яаж эхэлсэн тухай
2. Өвчин үүсэхэд нөлөөлсөн таагүй хүчин зүйл
3. Өвчний явц
4. Эмчилгээ хийсэн эсэх, үр дүн
5. Өсөлт хөгжилт хэвийн явагдсан эсэх

/365./ Парацетамолын насанд тохирох тунг сонго

1. 2 сараас 12 сартай хүүхдэд 100 мг
2. 12 сараас 3 настай хүүхдэд 100-125 мг
3. 3-5 настай хүүхдэд 250 мг
4. 12 сараас 3 настай хүүхдэд 250 мг
5. 3-5 настай хүүхдэд 500 мг

/366./ Нялх бага насны хүүхдийн хамрын салстын үрэвслийн үед илрэх зовуурь

1. Хамар битүүрэх
2. Хөхөө хөхөхөд саадтай
3. Зовуурьтай уйлагнах
4. Амаараа амьсгах
5. Шархирч хорсох

/367./ Амьсгал авах саадтай байдал ямар үед үүсэх вэ ?

1. Гуурсан хоолойн булчин агших
2. Төвөнхийн үрэвсэл
3. Хамрын салст хөөж хавагнах
4. Гадны биет залгих
5. Гуурсан хоолойн багтрааны сэдрэлийн үед

/368./ Сальбутамолын үйлчлэх механизм

1. Умай, зүрхнээс бусад эрхтний гөлгөр булчингийн α -рецепторыг идэвхжүүлэх

2. Захын судсыг тэлэх
 3. Сулралтын даралт бууруулах
 4. β -адреносаатуулагчийн эсрэг үйлдэлтэй
 5. Гуурсан хоолойн гилгэр булчинг сулруулах
- /369./ АЦХ-тай хүүхдийн гэрийн эмчилгээ
1. Халуун бууруулах
 2. Хоолойн өвдөлт намдаах
 3. Ханиалга багасгах
 4. Амьсгал бачуурлыг намжаах
 5. Асаргааг сайжруулах
- /370./ Гүйлсэн булчирхайн үрэвсэл үүсгэх нянгийн гол төлөөлөгчид
1. Ротавирус
 2. Стрептококк
 3. Клебсиелл
 4. Стафилококк
 5. Энтерококк
- /371./ Гуурсан хоолойн амьсгал ямар үед сонсогдох вэ?
1. Уушгинд авчилз үүсэхэд
 2. Эрүүл хүүхдийн төвөнх, мөгөөрсөн хоолой дээр
 3. Уушгины эд хатуурах
 4. Уушгины нэвчдэст үрэвсэл, буглаатай үед
 5. Гялтан хальс зузаарах
- /372./ АЦХ-ын үед зонхилон хэрэглэдэг эмийн бэлдмэл
1. Цэр ховхлох
 2. Ханиалга намдаах
 3. Халуун бууруулах
 4. Өвчин намдаах
 5. Судсаар шингэн сэлбэх
- /373./ Грам эерэг нянд нөлөөлөх антибиотик
1. Эритромицин
 2. Цефаломидин
 3. Ампициллин
 4. Цефалоспорин
 5. Тетрациклин
- /374./ Гуурсан хоолойн үрэвслийн үед өгүүлэх зовуурь
1. АЦХ-ын шинж бүхий зовуурь хэлэх
 2. Бага насны хүүхэд ханиалгах үед зовуурьтай уйлагнах
 3. Чээж нь шуугиж бөгшүүлж ханиалгах
 4. Том насны хүүхэд чээжээр хорсож өвдөх
 5. Ахлах насны хүүхэд хүчтэй ханиаснаас хэвлийн булчингаар өвдөх
- /375./ Бөглөршилт амьсгалын дутагдал үүсэх шалтгаан
1. Амьсгалын замд гадны биет орох
 2. Амьсгалын гуурс, гуурсанцар агчих
 3. Амьсгалын гуурс цэрээр бөглөрөх
 4. Агаар дах хүчилтөрөгчийн парциаль даралт буурах
 5. Уушгины эд, эс соривжин хатангирших
- /376./ АЦХ-тай хүүхдийг гэрээр эмчлэх заалт
1. Маш хүнд өвчин, хүнд хатгалгааны шинж тэмдэггүй
 2. Зөвхөн ханиадтай нярай хүүхэд
 3. Суурь өвчингүй буюу түүний хөнгөн зэрэгтэй
 4. Архаг өвчингүй
 5. Төвөнхийн бачууралтай
- /377./ Төвөнхийн үрэвслийг зонхилон үүсгэх вирусүүдийг нэрлэнэ үү?
1. Томуугийн А1, А2 хэвшинжүүд
 2. Иж томуугийн I, II хэвшинжүүд
 3. РС-вирус

4. Аденовирүс

5. Ротавирүс

/378./ Амьсгалын эрхтний эмгэгийн үндсэн зовуурь

1. Хамар битүүрэх

2. Хоолой сөөх, хоолой залгиур хөндүүрлэх

3. Ханиалгах

4. Чээжээр өвдөх

5. Амьсгаадах

/379./ АЦХ-тай халуунтай хүүхдэд өгөх зөвлөгөө

1. 38.50C хүртэлх халуунтай үед шингэн илүү уулгах

2. 38.50C дээш халуурвал парацетамол тохирсон тунгаар 6 цагийн зайтай халуун буутал хэрэглэх

3. Хөл гарыг чийгтэй алчуураар арчих

4. 380C хүрмэгц парацетамол өгөх

5. Үүсгэгчийн эсрэг эмийн бэлдмэл өгөх

/380./ Төвөнх, мөгөөрсөн хоолой, гуурсны цочмог үрэвслийг байршлаар нь хэрхэн ангилдаг вэ?

1. Эпиглотит

2. Төвөнх-мөгөөрсөн хоолойн

3. Төвөнх-мөгөөрсөн хоолой-гуурсны

4. Төвөнх-уушгины

5. Төвөнх-гүйлсэн булчирхайн

/381./ Чээжний тэмтрэх үзлэгээр юу тодорхойлох вэ ?

1. Чээжний хэнхэрцэгийн уян чанар

2. Дууны доргио

3. Өвдөлт

4. Арьсны зузаан

5. Өөхөн эдийн хөгжил

/382./ Бактерицид үйлчилгээтэй антибиотик

1. Пенициллин

2. Цефалоспорин

3. Полимиксин

4. Ванкомицин

5. Рифампицин

/383./ Гүйлсэн булчирхайн үрэвслийн үед илрэх эмнэлзүйн шинж

1. Гүйлсэн булчирхай хөөж томрох

2. Салстын өнгө улайж хүрэнтэх

3. Булчирхайн хонхруудад идээ хурах

4. Архаг үрэвслийн үед гүйлсэн булчирхай сорвижиж хатуурах

5. Зөөлөн тагнайн хажуу ирмэгтэй наалдах

/384./ Цэр шингэлэх уураг задлагч фермент

1. Панкипсин

2. Химопсин

3. Трипсин

4. Химотрипсин

5. Мукалтин

/385./ Бага насны хүүхдийн хамраас цус гоожих нь ховор байдаг юутай холбоотой вэ?

1. Доод жим байдаггүй

2. 2 нас хүртэлх хүүхдэд хамрын дайвар хөндий үүсгэвэр төдий буюу огт байдаггүй

3. Хамрын венийн хялгасан судас гавлын хөндийн тууш вентэй холбогдсон

4. Хамрын хөндийн доод хэсгийн салст бүрхэвчийн судаслаг эдийн хөгжил дутмаг

5. Хоногт 0.5-1 л салст ялгаруулах

/386./ Бага насны хүүхдэд гуурсан хоолойн үрэвслийн үед илрэх зовуурь, эмнэлзүйн шинж

1. Хоолонд дургүйцэх

2. Ханиах үедээ зовуурьтай уйлах

3. Ялангуяа шөнө хүчтэй ханиалгах

4. Өвчний 2 дахь 7 хоногоос ханиалга зөөлөрч цэр ховхрох
 5. Чээж хонхолзох
- /387./ Амьсгалын замын халдвараас хамгаалах дэглэм
1. Сайн унтуулах
 2. Цэвэр агаарт гаргах
 3. Гимнастик хийлгэх
 4. Тэжээллэг хоолоор хооллох
 5. Салст бүрхэвчийг цэвэр байлгах
- /388./ Дараах эмгэгүүдийн алинд нь тогшилтын чимээ бүдгэрч өөрчлөгдөх вэ?
1. Уушгины агааржилт ихсэх
 2. Уушгинд авчилз үүсэх
 3. Гялтанд хий хуралдах
 4. Тунгалгийн булчирхай томорох
 5. Гуурсан хоолойн бөглөршил
- /389./ Ерөнхий үзлэгээр үнэлэх шинж
1. Биеийн ерөнхий байдал
 2. Царайны илрэл
 3. Арьсны өнгө
 4. Биеийн байрлал
 5. Ухаан санааны байдал
- /390./ Гуурс тэлэгч эмүүдийг нэрлэ
1. Сальбутамол
 2. Адреналин
 3. Аминофиллин
 4. Пипольфен
 5. Супрастин
- /391./ Стрептококкоор үүсгэгдсэн залгиурын үрэвслийн ялгагдах шинж
1. Тунгалгийн булчирхай томорч хөндүүрлэх
 2. Гүйлсэн булчирхай хавагнан улайж сүвүүдэд идээ тогтох
 3. 390C-аас өндөр халуурч хоолой хүчтэй өвдөх
 4. Залгиурын салст хуурайших
 5. Хамраас салсархаг нус гоожих
- /392./ Чээжний гялтангийн үрэвслийн үед илрэх эмнэлзүйн шинжүүд
1. Ханиахад өвдөлт багасах
 2. Чээжийг дарах, өвчтэй талаараа хэвтэхэд багасах
 3. Эмгэгтэй талруу бөхийхөд өвдөлт ихсэх
 4. Амьсгал авах, гаргахад өвдөх
 5. Амьсгал авалт саадтай болох
- /393./ Макролидын бүлэгт багтах антибиотик
1. Олеондомицин
 2. Клиндамицин
 3. Эритромицин
 4. Линкомицин
 5. Оксациллин
- /394./ Ханиалга намдаах төвийн үйлдэлтэй эм
1. Либексин
 2. Кодеин
 3. Балтикс
 4. Этилморфин
 5. Абехол
- /395./ Амьсгалын цочмог халдварын үед бага насны хүүхдийн хамрын салст хөөж хавагнахын шалтгаан нь юу вэ?
1. Хамар жижигхэн богинохон
 2. Салст бүрхэвч хөвсгөр
 3. Хамрын хөндий нарийхан
 4. Тунгалгийн болон цусны судсаар баялаг

5. Доод жим байдаггүй
- /396./ Амьсгалын эрхтнийг шинжлэн судлах аргууд
1. Асуумж
 2. Бодит үзлэг
 3. Лаборатор
 4. Дуран
 5. Рентген шинжилгээ
- /397./ АЦХ-тай хүүхдэд халуун бууруулах эмчилгээг хэдийд хийх вэ?
1. Халуурах нь биеийн хамгаалах урвал учраас эмчилгээ хийхгүй
 2. Хүүхдийн халуун 38.50C-аас дээш үед
 3. Субфебрил халууралттай үед
 4. Халуурахаараа татдаг гэсэн өгүүлэмжтэй
 5. Халуунтай нярай хүүхэд
- /398./ Харах үзлэгээр төвөнхийн үрэвсэлтэй хүүхдэд илрэх шинж
1. Хүүхдийн царай цонхийж цайх
 2. Хамар-уруул орчмоор хөхөлбий туяатай
 3. Зовуурьтай шаналангуй
 4. Амьсгал авах үед туслах булчингийн оролцоо ихсэх
 5. Хяхатнасан амьсгал зайнаас сонсогдох
- /399./ Холимог амьсгаадалт ямар үед үүсэх вэ ?
1. Чээжний гялтан хальсны үрэвсэл
 2. Цусны бага эргэлтийн зогсонгишил
 3. Гэдэс дүүрэх
 4. Хэвлийн хөндийд шингэн хуралдах
 5. Хүнд сульдаатай хүүхдэд
- /400./ АЦҮ-ийн үед пенициллин тэсвэртэй үед ямар антибиотик сонгох вэ?
1. Цефаломизин
 2. Гентамицин
 3. Линкомицин
 4. Эритромицин
 5. Ампициллин
- /401./ Гүйлсэн булчирхайн үрэвслийн үед ахлах насны хүүхдэд илрэх зовуурь
1. Хоолой торох, юм залгихад хөндүүрлэх,
 2. Үе мөчөөр өвдөх
 3. Зүрхээр хөндүүрлэх
 4. Хуурай ханиах
 5. Хамар битүүрэх
- /402./ Зүрхний дутагдлын эмгэг жамд орохгүйг заа.
- A. Агшилтын эзлэхүүн багасах
 - B. Зүрхний булчинд К-ийн хуваарилалт алдагдах
 - C. Минутын эзлэхүүн ихсэх
 - D. Хүчилтөрөгчгүйдэл
 - E. Венийн даралт ихсэх
- /403./ Фаллогийн дөрвөлд аль нь орохгүй вэ?
- A. Уушгины артерийн нарийсалт
 - B. Аортын нарийсалт
 - C. Ховдол хоорондын таславчийн цоорхой
 - D. Аорт баруун тийш хэлтийх
 - E. Баруун ховдлын хана зузаарах
- /404./ Бага насны хүүхдэд тохиолдох зүрхний булчингийн үрэвсэл голчлон ямар шалтгаантай байх вэ?
- A. Нян
 - B. Вирүс
 - C. Харшил
 - D. Хордлого
 - E. Холбогч эдийн түгээмэл үрэвсэл

/405./ Цусны эргэлтийн алдагдлын II а үед ямар шинж тэмдэг илрэхгүй вэ?

- A. Зүрхний цохилт түргэсэх
- B. Амьсгаадах
- C. Хөхрөх
- D. Элэг томрох
- E. Хэвлийд шингэн хуралдах

/406./ Хэрэхийн шалтгаантай олдмол гажгаас хамгийн элбэг тохиолдохыг нь сонго.

- A. Гол судасны хавхлагын дутмагшил
- B. Гол судасны хавхлагын нүхний нарийсал
- C. Хоёр хавтаст хавхлагын дутмагшил
- D. Хоёр хавтаст хавхлагын нүхний нарийсал
- E. Гурван хавтаст хавхлагын дутмагшил

/407./ Тосгуур хоорондын таславчийн цоорхойтой хүүхдийн эмнэлзүй хэдэн наснаас илэрч эхлэх вэ?

- A. 1 нас
- B. 5 нас
- C. 2 нас
- D. Төрөнгүүтээ
- E. 10 нас

/408./ Зүрхний гликозидын барих тун ямар байх вэ?

- A. Хангах тунгийн хагастай тэнцүү
- B. Хүүхдийн биеийн жингээс хамаарна
- C. Тухайн бэлдмэлийн биеэс зайлуулагдах коэффициенттэй тэнцүү
- D. Зүрхний дутлын зэргээс хамаарна
- E. Ямар аргаар хэрэглэснээс хамаарна

/409./ Аль нь хүүхдэд хамгийн элбэг тохиолддог вэ?

- A. Параксизмийн тахикарди
- B. Экстрасистол
- C. АВ бүтэн хориг
- D. Амьсгалын гаралтай зүрхний хэм алдагдал
- E. Синусын брадикарди

/410./ Хоёр хавтаст хавхлагын дутмагшлын үед рентген зурагт дараах шинжүүдээс аль нь илрэхгүй вэ?

- A. Зүрхний бэлхүүс тодрох
- B. Зүрхний зүүн тосгуур томрох
- C. Зүрх-цээжний индекс ихсэх
- D. Зүрхний бэлхүүс тэгшрэх
- E. Зүүн ховдол томрох

/411./ ЮРА өвчний рентген шинж

- A. Үений завсар холдох
- B. Булчин хатангирших
- C. Үе орчим яс сийрэгжсэн
- D. Үе үрэвссэн
- E. Үений хөшөнги

/412./ Зүрхний дутагдал ихэвчлэн зүрхний аль хэсгийн эмгэгтэй холбоотой үүсэх вэ?

- A. Зүрхний дотор бүрхэвч
- B. Зүрхний булчин
- C. Үнхэлцэг хальс
- D. Сэрэл дамжуулах тогтолцоо
- E. Титэм судас

/413./ Хоёр хавтаст хавхлагын дутмагшлын үед шуугиан дараах цэгт сонсогдоно.

- A. Зүрхний оройд
- B. II цэгт
- C. III цэгт
- D. IV цэгт
- E. V цэгт

- /414./ Зүрхний төрөлхийн гажгийг эмгэг жам, эмнэлзүйгээр нь хэдэн үе шат болгодог вэ?
- A. 6
 - B. 5
 - C. 4
 - D. 3
 - E. 2
- /415./ Хэрлэгийн үндсэн шалгуур аль нь вэ?
- A. Үеэр хэрж өвдөх, халуурах
 - B. Хамраас цус гарах
 - C. Ядрах
 - D. С-урвалж уураг ихсэх
 - E. Олон үений үрэвсэл
- /416./ Миокардитын оношлогооны I шатны өндөр оноот шинж аль нь вэ?
- A. Төвөргөөнт хэм
 - B. АВ хориг
 - C. I авиа бүдгэрэх
 - D. ЭКГ-д зүрхний булчин томорсон
 - E. Зүрхний дутагдалтай байх
- /417./ Хэрэх өвчний үед ямар хавхлага илүүтэй гэмтэх вэ?
- A. Гол судасны хавхлага
 - B. Хоёр хавтаст хавхлага
 - C. Гурван хавтаст хавхлага
 - D. Уушгины артерийн хавхлага
 - E. Аль аль нь
- /418./ Хоёр хавтаст хавхлагын дутагдлын үед шуугиан аль цэгт сонсогдох вэ?
- A. I
 - B. II
 - C. III
 - D. IV
 - E. V
- /419./ Ямар тохиолдолд далд явцтай хэрэх гэж үзэх вэ?
- A. Хүүхэд өндөр халуурсан
 - B. Эмнэлзүй ба шинжилгээнд өөрчлөлтгүй атлаа олдмол гажиг үүссэн
 - C. Эмнэлзүйн илрэлгүй атлаа шинжилгээнд УЭТХ ихэссэн
 - D. Бодит үзлэг, шинжилгээнд өөрчлөлтгүй ч зүрхээр хатгаж өвдөнө гэсэн зовиуртай
 - E. Үеэр өвдөж, хавдсан
- /420./ Эйзенменгерийн хамшинжийн гол шинж
- A. Хөхрөх
 - B. Уушгины артерийн даралт ихсэх
 - C. Цусны урсгал баруунаас зүүн рүү чиглэх
 - D. Цусны урсгал зүүнээс баруун руу чиглэх
 - E. Уушгины артер дээр II авианы өргөлт тодрох
- /421./ Бага эргэлтэнд баяжилттай, хөхрөлттэй гажигт аль нь орох вэ?
- A. Гол судасны коарктац
 - B. Ховдол хоорондын таславчийн цоорхой
 - C. Эйзенменгер хам шинж
 - D. Эбштейны өвчин
 - E. Фаллогийн дөрвөл
- /422./ Миокардитын оношилгооны I шатны дунд оноот шинж аль нь вэ?
- A. Зүрхээр өвдөх
 - B. ЭКГ-д зүрхний булчин томорсон
 - C. Бодит үзлэгт зүрх томорсон
 - D. Эктоник хэмнэл
 - E. АВ хориг
- /423./ Цочмог явцтай анхдагч хэрэхийн үед зүрх гэмтэх нь хэр элбэг тохиолдох вэ?
- A. 10-15%

- B. 20-25%
- C. 40-45%
- D. 60-55%
- E. 80-85%

/424./ Цусны эргэлтийн алдагдлын I үед ямар шинж тэмдэг илрэх вэ?

- A. Ачааллын үед амьсгаадна
- B. Тайван үед зүрх дэлсэж, амьсгаадна
- C. Хүүхэд хөхөө амарч хөхнө
- D. Элэг томорно
- E. Хавагнана

/425./ Аортын нарийслын үед эгзэгтэй байдал хэдийд үүсэх вэ?

- A. Ахлах насны хүүхдэд
- B. Нарийсалт бага үед
- C. Судасны голч 0.5 см-ээс бага, хүүхэд 6 сар хүрээгүй үед
- D. Судасны голч 0.5 см-с их, хүүхэд 6 сар хүрээгүй үед
- E. Судасны голч 0.5 см-с бага, хүүхэд 6 сараас дээш настай үед

/426./ 3-7 настай хүүхдэд ЮРА илрэх онцлог

- A. Рентгенд яс мөгөөрсний гэмтэл илэрнэ
- B. Серологит өөрчлөлт илэрнэ
- C. Үений өөрчлөлт 2 талдаа ижил бус
- D. Булчин хатангиршина
- E. Үений өөрчлөлт хөнгөн

/427./ Төрөлхийн гажгуудын дотроос хамгийн элбэг тохиолддог нь аль нь вэ?

- A. Тосгуур хоорондын таславчийн цоорхой
- B. Ховдол хоорондын таславчийн цоорхой
- C. Артерийн битүүрээгүй цорго
- D. Фаллогийн өвчин
- E. Нэгдсэн ховдол тосгуур

/428./ Ховдол хоорондын таславчийн цоорхойн үед илрэхгүй шинжүүд

- A. Амьсгалын замын цочмог өвчнөөр байнга өвдөх
- B. Амьсгаадах
- C. Диастолын даралт хэвийн байна
- D. Нойтон хэржигнүүр сонсогдоно
- E. Систолын даралт ихэснэ

/429./ Чонон яр өвчний шинжид орохгүйг заа.

- A. Үений үрэвсэл
- B. Нарны гэрэлд мэдрэг
- C. Үений хөшингө
- D. Эрвээхий хэлбэрийн тууралт
- E. Антинуклеар эсрэгбие

/430./ Хэрэхээр ямар насны хүүхэд ихэвчлэн өвчлөх вэ?

- A. Хөхүүл
- B. 2-3 нас
- C. 4-6 нас
- D. 7-15 нас
- E. 15 аас дээш

/431./ Артерийн битүүрээгүй цоргын үед сонсогдох онцлог шуугиан

- A. Систолын шуугиан
- B. . Диастолын шуугиан
- C. Сулралын богино шуугиан
- D. Трехем-Стиллийн шуугиан
- E. Машины шуугиан

/432./ Зүрхний дутмагшлын I зэргийн үед илрэхгүй шинжийг заа.

- A. Тайван үед зүрхний цохилт олшрох
- B. Ачааллын үед амьсгаадах
- C. Тасалдаж хөхөх

- D. Хамар-уруулын орчим хөхрөх
- E. Бодисын солилцоо хямрах

/433./ Гол судасны хавхлагын нүхний нарийслын үед ямар шуугиан хаана сонсогдох вэ?

- A. II цэгт сулралын шуугиан
- B. II цэгт агшилтын шуугиан
- C. III цэгт сулралын шуугиан
- D. III цэгт агшилтын шуугиан
- E. I цэгт сулралын шуугиан

/434./ Хүүхдийн зүрхний төрөлхийн гажгийн шалтгаанд аль нь орохгүй вэ?

- A. Жирэмсний сүүлийн 3 сард хүнд хордлоготой байх
- B. Удамшил
- C. Ионжуулах цацраг
- D. Жирэмсний эхний 3 сард хүнд хордлоготой байх
- E. Хорт зуршил

/435./ Ховдол хоорондын таславчийн цоорхой гажгийн үед бага эргэлтэнд цус хомсдох учраас хүүхэд ханиад хүрэмтгий байна.

/436./ 46. Ховдол хоорондын таславчийн цоорхойн төгсгөлийн шатанд бага эргэлтийн даралт эрс ихсэх учраас цус юүлэлтийн чиглэл өөрчлөгдөн хөхрөлт илэрнэ.

/437./ Томуугийн вирүс нь кардиомиоцит эсийг шууд гэмтээх учраас зүрхний булчинг үрэвсүүлнэ.

/438./ Зүрхний дутагдлын үед зүрхний булчингийн агшилт суларснаас биеэр цус эргэх үйл ажиллагаа хямарна.

/439./ Хэрэх өвчний гол үүсгэгч нь цус задлагч стрептококк учраас эмгэгтөрөгч шууд зүрхийг гэмтээнэ.

/440./ Хомхойн халдварын үед ямар ямар хожуу үлдэц илрэх вэ?

- 1. Сохрох
- 2. Дүлийрэх
- 3. Тархины эмгэгшил
- 4. Сэтгэц-хөдөлгөөний хоцрогдол
- 5. Уушгины үрэвсэл

/441./ Төрөх өрөөнд ургийн ус эрт гарсан, илүү тээлттэй эх төрөх гэж байна. Нярайд шаардлагатай хэрэгслийг бэлдэнэ үү.

- 1. Дулаан цацруулагчтай ширээ
- 2. Нярайг хуурайшуулах даавуу, дулаан өлгий
- 3. Салиа соруулах төхөөрөмж
- 4. Хүүдий, маск
- 5. Шаардлагатай эм

/442./ Төрөлхийн тэмбүүтэй хүүхдэд ямар антибиотик сонгох вэ?

- 1. Эритромицин
- 2. Амоксациллин
- 3. Хлорамфеникол
- 4. Пенициллин G
- 5. Ципрофлоксацин

/443./ Нярай хүүхэд дулаанаа алдах замуудыг нэрлэнэ үү.

- 1. Зулайгаар дулаанаа цацруулах
- 2. Орчиндоо шилжүүлж алдах
- 3. Хавьтлын замаар
- 4. Ууршлын замаар
- 5. Агаар дуслын замаар

/444./ Нярайн халдвар үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс:

1. Ураг орчмын шингэн эрт гарах
2. Эхийн бэлгийн замын халдвар
3. Бага жинтэй төрөх
4. Төрөхдөө бүтэх
5. Гараа муу угаах

/445./ Нярай хүүхдэд антибиотикийг хэрхэн сонгох вэ?

1. Нярайд өвчин үүсгэгчийн эсрэг хамгийн сайн үйлчлэх антибиотикийг сонгоно.
2. Антибиотик мэдрэгийг тодорхойлох боломжгүй, эхэлж хийсэн антибиотикт сайжрал өгөхгүй бол хоёр дахь сонголтын антибиотикийг хэрэглэх буюу антибиотикийг хавсарч хэрэглэнэ
3. Хоёрдугаар сонголтын антибиотикийг 3 дахь өдрөөс хийж эхэлнэ.
4. Үүсгэгчийг тодорхойлсны дараа антибиотикийг өөрчилнө
5. Заавал 3 антибиотик хавсарч хэрэглэнэ

/446./ Нярайн цус задрах өвчнийг сэжиглэж байгаа үед ямар шинжилгээнүүдийг хийхээр төлөвлөх вэ?

1. Эх, хүүхдийн цусны бүлэг, резус хүчин зүйлийг тодорхойлох
2. Хүүхдийн захын цусанд ретикулоцит тодорхойлох
3. Хүүхдийн цусны билирубиныг тодорхойлох
4. Кумбсын сорил
5. Хүүхдийн цусны уураг тодорхойлох

/447./ Нярайн гемостазын онцлог юу вэ?

1. Улаан эс 1 мм³-т 6.09 сая
2. Хоёр төрлийн гемоглобин агуулдаг
3. Цусан дахь фибриногений хэмжээ бага
4. Цус бүлэгнэлтийн II, VII, IX, X хүчин зүйлс бага
5. Эргэлдэх цусны хэмжээ биеийн цулын 11%- тай тэнцүү

/448./ Бүтэлттэй төрсөн нярайг цочрооход дараах аргын аль нь тохиромжгүй вэ?

1. Түргэн хуурайшуулангаа цочроох
2. Өгзөгийг алгадах
3. Хөлийн улыг алгадах
4. Халуун, хүйтэн усаар ээлжлэн шүрших
5. Нурууг илэх

/449./ Анхдагч апноэгийн үед илрэх шинжийг сонгоно уу?

1. Зүрхний цохилтын тоо цөөрөх
2. Цочрооход хариу үзүүлэх
3. Арьс цонхийж цайх
4. Гасп хэлбэрээр амьсгалахыг оролдох
5. Цусны даралт унах

/450./ Эрт илрэлтэй үжлийн үед ихэвчлэн тохиолдох үүсгэгчийг заана уу.

1. Псевдомонас
2. В-бүлгийн стрептококк
3. Стафилококк
4. Гэдэсний савханцар
5. Клебсиел

/451./ Нярай хүүхэд амьдралын эхний хоногуудад шээс нь ховорддог шалтгаан

1. Шингэн уулгаагүйгээс
2. Дулаан өлгийдөж, халууцуулснаас
3. Бөөрний дутагдлаас
4. Бие махбод шингэнээ хадгалах үүднээс авч буй физиологийн үзэгдэл
5. Ангир уураг хэт багаас

/452./ Уушгины үрэвсэл үүсэхэд нөлөөлөх урьдал хүчин зүйлийг заана уу.

1. Ураг орчмын шингэн урьтаж гараад, усгүй үе удаан үргэлжлэх
2. Төрөх үед үтрээний үзлэгийг олон дахин хийх
3. Эх нь ямар нэг халдвартай байх /амьсгалын, шээс бэлгийн гэх мэт/
4. Дутуу төрөлт
5. Ургийн хөгжлийн саатал

/453./ Амьсгалын дистресс хамшинжийн үед авах арга хэмжээний зарчмыг заана уу.

1. Хүүхдийг тайван байлгах
2. Нярайг дулаан байлгах
3. Салиаг сайтар соруулж, хахахаас сэргийлэх
4. Хүчилтөрөгч өгөх
5. Амьсгал зүрх судасны үйл ажиллагааг тогтмол хянах

/454./ Нярайн халдварын эмчилгээний зарчимд орохгүй зүйлийг нэрлэ

1. Антибиотик эмчилгээ
2. Дэмжих эмчилгээ
3. Шинж тэмдгийн эмчилгээ
4. Эхийн сүүгээр хооллохгүй, тусгаарлах
5. Вирүсийн эсрэг эмчилгээ

/455./ Нярайн хүй өтгөнөөр бохирдсон, идээлж, улайгаагүй байвал яаж цэвэрлэх вэ?

1. Антибиотиктой цацлага хийнэ
2. Цэвэр зүйлээр дарж бооно
3. Спиртээр цэвэрлэнэ
4. Савантай буцалсан бүлээн усаар угааж, хуурайшуулна
5. Эмнэлэгт хэвтүүлнэ

/456./ Ямар тохиолдолд нярайд антибиотик эмчилгээг эхлэх вэ?

1. Нярайн нян судлалын шинжилгээ эерэг байвал
2. Нярайд үжлийн шүүлтүүрээс 2 үзүүлэлт эерэг байвал
3. Нярайд халдварын эмнэл зүй тодорхой байвал
4. Нярай бүтэлттэй төрсөн бол
5. Нярай дутуу төрсөн бол

/457./ Хөх чинэсэн үед хүүхдээ хөхүүлэхийн өмнө окситоцины ялгаралтыг хэрхэн нэмэгдүүлэх вэ?

1. Бүлээн шүршүүрт орох
2. Хөхөндөө иллэг хийх
3. Хөхний толгойг имрэх
4. Хөхөндөө бүлээн жин тавих
5. Хүзүү нуруунд иллэг хийх

/458./ Нярайг хэдийд амлуулах вэ?

1. Хөхөнд сүү орсон үед
2. 24 цаг болоод
3. Ангир уургаа саасны дараа 3 цаг тутамд
4. 30 минутаас 1 цагийн дотор
5. Төрсний дараа 20 минутын дотор амлуулна

/459./ Төрөлхийн тэмбүүтэй хүүхдэд илрэх гол шинж тэмдэг юу вэ?

1. Ургийн өсөлтийн саатал
2. Хамар битүү
3. Гар, хөлийн улаар цэврүүтэй
4. Ургийн ус бохир ногоон
5. Бүтэлттэй төрдөг

/460./ Түгээмэл тохиолддог амьсгалын дистресс хамшинжийг нэрлэнэ үү

1. Гиалин бүрхүүлт өвчин
2. Шилжилтийн үеийн амьсгаадалт
3. Уушгины үрэвсэл
4. Зунгагт хахах хамшинж
5. Пневмоторакс

/461./ Гэдэсний үхжилт үрэвслийн үед гэдэс-ходоодны талаас гарах өөрчлөлтүүдийг заана уу.

1. Гэдэс дүүрэх
2. Ходоодны үлдэгдэл агууламж ихсэх буюу хоол шингэхгүй байх
3. Бөөлжих
4. Цустай баах
5. Хэвлийн хана улайх

/462./ Зунгаагаар хахсан бүтэлттэй төрсөн нярайд цаашид гарах хүндрэлийг заана уу.

1. Авчилз үүснэ
2. Уушгины үрэвсэл
3. Гуурсан хоолой бөглөрөх
4. Уушги хэт тэлэгдэх
5. 4Плеврит

/463./ Нярайн үжил ба мэнэнгийн үед 1-р сонголтын антибиотик аль нь вэ?

1. Прокайн пенициллин
2. Гентамицин
3. Эритромицин
4. Ампициллин
5. Клоксациллин

/464./ Трансфераза ферментийн идэвхжлийг бууруулах хүчин зүйлийг заана уу

1. Хүчилтөрөгчийн дутмагшил
2. Халдварын гаралтай өвчин
3. Нярайн дулаан алдалт
4. Бамбай булчирхайн дутал
5. Халууралт

/465./ Дасан зохицлын үед бөөрний талаас гарах өөрчлөлтийг заана уу.

1. Шээсээр уураг ялгарах
2. Шээс ховордох
3. Шээсний хүчлийн инфаркт
4. Цустай шээх
5. Шээхэд өвдөх

/466./ Бүтэлтийн зөв тодорхойлолтыг тэмдэглэнэ үү

1. Амьсгалахгүй, зүрх цохилохгүй, амьдын шинжгүй төрөх
2. Ураг орчмын шингэн булингартай байх
3. Хүүхэд төрмөгц уйлахгүй байх
4. Амьд төрөлтийн бусад шинж илэрч байвч хүүхэд амьсгалахгүй буюу амьсгалын хэм алдагдах
5. Нярай хэвийн амьсгалж байснаа хэсэг хугацааны дараа амьсгалахгүй болж, царай хөхрөх

/467./ Бүтэлтийн хожуу үед дараах хүндрэлээс аль нь тохиолдож болох вэ?

1. Халдвар (уушгины хатгалгаа, мэнэн)
2. Мэдрэлийн эмгэгүүд
3. Хүчилтөрөгч эмчилгээний хүндрэл
4. Ургийн цусны эргэлт эргэж сэргэх
5. Бөөрний цочмог дутагдал

/468./ Даарсан хүүхдийг хэрхэн дулаацуулах вэ?

1. Нярайг нүцгэлж, эхийн нүцгэн цээжинд наана
2. Толгойд малгай өмсгөнө
3. Хөхүүлнэ
4. Халуун усанд оруулна
5. Эмнэлэгт яаралтай илгээнэ

/469./ Биеийн дулаан бууралтын эмнэлзүйн шинжүүдийг заана уу.

1. Амьсгал түргэсч, зүрхний цохилт хурдсана
2. Хөдөлгөөний идэвх суларч, хөхөндөө муудна
3. Бие нь хөрч, хөдөлгөөн ихсэнэ
4. Амьсгал ба зүрхний цохилт цөөрнө
5. Арьсны өнгө ягаарна

/470./ Нярай хүүхдэд допаминыг их тунгаар хэрэглэхэд гарах гаж нөлөөг нэрлэнэ үү?

1. Зүрхний цохилт олшрох
2. Зүрхний хэм алдагдах
3. Уушгины даралт ихсэх
4. Зүрхний цохилт удаашрах
5. Зах хязгаарын судас өргөсөх

/471./ Нярай хүүхдийн биеийн хэвийн халуун хэдэн хэм байдаг вэ?

1. 37-38.0C
2. 36-38.50C
3. 35-36 0C
4. 36.5-37.40C
5. 35-360C

/472./ Цус задрах өвчний үед цус орлуулан сэлбэх эмчилгээний заалтыг нэрлэнэ үү.

1. Цусны билирубин >342 мкмол/л
2. Билирубины цагийн өсөлт >6 мкмол/л
3. Хүйн цусанд билирубиний хэмжээ >60 мкмол/л
4. Цусны билирубин >205 мкмол/л
5. Хүйн цусанд билирубины хэмжээ >45 мкмол/л

/473./ Бүтэлттэй төрсөн нярайд авах зөв арга хэмжээг ол

1. Түргэн хугацаанд хуурайшуулан, зөв байрлуулна
2. Амьсгалын замыг чөлөөлнө
3. Хиймэл амьсгал хийнэ
4. Төрмөгц алгадаж, сэгсэрч цочрооно
5. Зүрхэнд массаж хийж ам хамраас салиаг соруулна

/474./ Ургийн халдвар хэдийд үүсдэг вэ?

1. Төрсний дараа
2. Төрөхөөс өмнө
3. Хөхний сүүгээр
4. Төрөх үед
5. Жирэмслэхээс өмнө

/475./ Амьсгалын дистресс хамшинжийн хүндрэлд аль нь хамаарах вэ?

1. Артерийн цорго битүүрээгүй
2. Тархины ховдлын эргэн тойронд цус харвах
3. Үрэвсэлт өөрчлөлт илрэх
4. Хүчилтөрөгч эмчилгээний хүндрэл үүсэх
5. Уушгинд цус харвах

/476./ Нярайн булчингийн сулрал ямар эмгэгүүдийн үед илрэх вэ?

1. Бүтэлт
2. Мэдрэл-булчингийн төрөлхийн өвчин
3. Тархи-нугасны гэмтэл
4. Дауны хамшинж
5. Дутуу нярай

/477./ Амьсгалын дистресс хамшинжийн үед илрэх эмнэлзүйн нийтлэг шинжүүд:

1. Амьсгал олшрох
2. Амьсгал гаргахдаа яраглах
3. Амьсгалд туслах булчингууд оролцох
4. Хөхрөх
5. Чээжний 2 тал амьсгалд жигд бус оролцох

/478./ Төрөх өрөөнд эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг чандлан сахина. Үүнд:

1. Цэвэр гар
2. Цэвэр талбай
3. Цэвэр даавуу, өлгий
4. Хүй таслах, боох хэрэгсэл ариун байх
5. Эх, нярайд хэрэглэх багаж, хэрэгсэл ариун

/479./ Ураг, нярайн халдварт өртөх эрсдэлт хүчин зүйлд аль нь хамаарах вэ?

1. Ураг орчмын шингэн үнэртэй байх, ус ихтэй байх
2. Дутуу төрөлт
3. Эх барихын ажилбарууд
4. Эхийн эрүүл ахуй сайн
5. Бүтэлттэй төрж, сэхээн амьдруулах арга хэмжээ авагдсан байх

/480./ Бага жинтэй нярайд дулаан байлгах аргуудыг нэрлэнэ үү.

1. Дулаан өрөө тасалгаа

2. Дээрээсээ халдаг ширээ
3. Имж эх арга
4. Агаар халаагчтай инкубатор
5. Малгай өмсгөх

/481./ Нярай хүүхдийг хөхөөр хооллохтой холбоотой буруу зөвлөгөөг олно уу.

1. Ангир уураг нь хүүхдэд хэрэгцээтэй шимт бодисыг агуулсан байдаг
2. Шөнө хөхүүлэх нь сүүний гарцыг бууруулна
3. Хөхөө ойр ойрхон хүүхдээ хүссэн үед нь хөхүүлэх нь чухал
4. Ангир уураг маш бага хэмжээтэй тул чихэртэй усаар нэмж угжина
5. Шөнө хөхүүлэх нь сүүний гарцыг сайжруулна

/482./ Сурфактант ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

1. Уушгины дотор хананы гадаргууны таталцлыг ихэсгэнэ
2. Цулцангийн дотор хананы гадаргууны таталцлыг багасгана
3. Авчилз үүсгэнэ
4. Цулцангууд хоорондоо наалдахаас сэргийлнэ
5. Уушгины агааржилтыг бууруулна

/483./ Ямар тохиолдолд цитомегаловирусийн төрөлхийн халдвартай гэж үзэх вэ?

1. Эх, хүүхдийн цусанд ЦМВ-ийн эсрэг IgG илэрсэн
2. Цитомегаловирусийн геном илэрсэн
3. Давтан шинжилгээгээр хүүхдийн цусны ЦМВ-ийн эсрэг IgG эхийнхээс 1.5-2 дахин буурсан

4. Хүүхдийн цусны ЦМВ-ийн эсрэг IgG эхийнхээс 4 дахин өндөр
5. Хүүхдийн цусны ЦМВ-ийн эсрэг IgG эхийнхээс 4 дахин бага

/484./ Нярайн шарлалтын шалтгааныг заана уу.

1. Цөсний сувгийн төрөлхийн битүүрэл
2. Төрөлхийн цитомегаловирусийн халдвар
3. Элэгний үрэвсэл
4. Төрөлхийн тэмбүү
5. Галактоземи

/485./ Физиологийн шарлалт эмгэг шарлалтаас ялгагдах шинж нь:

1. Төрмөгц үүсээд удаан үргэлжилдэг
2. Төрсний дараах 2-3 хоногт үүсдэг
3. Шарлалт арилсны дараа дахин үүсч болдог
4. 10-аас илүүгүй хоноод арилдаг, биенд ямар нэгэн зовуургүй
5. Билирубины хэмжээ 12 мг%-аас их болно

/486./ Эх нярай 2 төрөхөөс гарч байна. Таны өгсөн зөвлөгөөнд байж боломгүй нь:

1. Хөхөөрөө хоолло, хүссэн үед нь хөхүүл
2. Хүй бохирдвол савантай бүлээн усаар угааж хатаа
3. Өрхийн эмч сувилагчаас зөвлөгөө авч байх
4. Хүйтний улирал тул гадаа гаргаж болохгүй ба сард 1 удаа усанд оруул
5. Аюултай шинжийг ажиглах

/487./ Амьсгалын дистресс хамшинжийн хөнгөн үед хүчилтөрөгч эмчилгээг хэрхэн хийх вэ?

1. Аппаратаар өгнө
2. Майхан ба маскаар өгнө
3. Чөлөөт урсгалаар өндөр даралтаар өгнө
4. 2-6 хоног хүчилтөрөгч өгнө
5. 2 долоо хоногоос доошгүй хугацаагаар өгнө

/488./ Нярайн дулаан алдалтын шалтгаанд аль нь орох вэ?

1. Биеийн нэг кг жинд ноогдох талбай их
2. Амьсгалын минутын эзлэхүүн насанд хүрэгчдийнхээс их
3. Бор өөх багатай
4. Хөхний сүүнээс өөр хоол иддэггүй учраас
5. Арьсан доорх өөхөн эдийн хөгжил сайн

/489./ Нярайн эмчилгээнд фурсемидийн үзүүлэх үйлчилгээ юу вэ?

1. Бөөрний ачаалал ихэсгэх
2. Шээс хөөх

3. Даралт ихэсгэх
4. Судас өргөсгөх
5. Зүрхний дутагдлыг нэмэгдүүлэх

/490./ Амьдралын эхний хоногт шарлалт үүсгэх шалтгааныг заана уу.

1. Нярайн цус задрах өвчин
2. Үжил
3. Ургийн халдвар
4. Цус харвалт
5. Цусны эс олширох

/491./ Төрөх өрөөнд түргэн төрөлтөөр төрсөн нярай амьдралын эхний минутад амьсгал тогтворжоогүй, зүрхний цохилт 1 минутанд 140 удаа, хөл ба гарын үзүүр хөхөрсөн, булчингийн хүчдэл суларсан, цочролд сул хариулна. Бүтэлтийг ангилж, Аггарын оноог тогтооно уу.

1. Хүнд бүтэлт
2. Хүндэвтэр бүтэлт
3. Аггарын оноо 5
4. Аггарын оноо 6
5. Аггарын оноо 7

/492./ Нярай хүүхэд дулаан алдахаас сэргийлэхэд аль нь буруу вэ?

1. Эхийн нүцгэн биед нааж, дулаан хучих
2. Төрмөгц нь хуурайшуулах
3. Өрөө тасалгаа дулаан байх
4. Чанга өлгийдөх
5. Малгай өмсгөнө

/493./ Уушгины бус гаралтай амьсгалын дистресс хамшинжийн шалтгааныг заа

1. Ургийн цусны эргэлт давтагдах
2. Тархины хаван
3. Зүрхний төрөлхийн гажиг
4. Бодисын солилцооны хямрал
5. Тархи-нугасны гэмтэл

/494./ Хламидын шалтгаант нүдний үрэвслийг хэрхэн эмчлэхийг заана уу.

1. Тетрациклины тосон түрхлэг хэрэглэнэ
2. Эритромицины тосон түрхлэг хэрэглэнэ
3. Пенициллин тарина
4. Эритромицины сироп уухаар хэрэглэнэ
5. Ампициллин тарина

/495./ Цусны чихэр багадагт хэдийд зонхилон тохиолдох вэ?

1. Төрмөгц
2. Амьдралын эхний 24 цагт
3. Амьдралын эхний 48 цагт
4. Амьдралын эхний 3 хоногт
5. Амьдралын эхний 7 хоногт

/496./ Дараах шинжүүдийн аль нь халдварын үед аюултай шинжид орох вэ?

1. Амьсгалын тоо олширох
2. Ихээр бөөлжих ба суулгах
3. Чээж хүчтэй хонхолзох
4. Биеийн халуун хэт буурах
5. Татах

/497./ Амьсгалын дистресс хамшинжийн эмнэлзүйн шинж тэмдгийг заана уу.

1. Амьсгалын тоо олширох
2. Яраглах
3. Чээж хонхолзох
4. Хөхрөх
5. Хамрын угалз сарталзах

/498./ Цитомегаловирусийн төрөлхийн халдварын үед илрэх эмнэлзүйн гол шинжүүд:

1. Цусархаг тууралт

2. Элэг, дэлүү томрох
3. Шарлалт
4. Гидроцефали
5. Том жинтэй төрөх

/499./ Гипотермийн эмнэлзүйн шинжүүдийг сонгоно уу.

1. Амьсгал түргэсч, зүрхний цохилт хурдасна
2. Хөдөлгөөний идэвх суларч, хөхөндөө муудна
3. Бие нь хөрч, хөдөлгөөн ихсэнэ
4. Амьсгал, зүрхний цохилтын тоо цөөрч, амин чухал эрхтний үйл ажиллагаа дарангуйлагдана
5. Арьсны өнгө ягаарна

/500./ Нярайд хийгддэг урдчилан сэргийлэх арга хэмжээг заана уу

1. Нүдний үрэвслээс сэргийлэх
2. Цусархаг хамшинжээс сэргийлж К-аминдэм тарих
3. БЦЖ, халдварт саа, В-гепатитын эсрэг вакцин тарих
4. Халдвараас сэргийлж тусгаарлах
5. Антибиотик уулгах

/501./ Диабетийн эмнэлзүйн шинжүүд илрэхээс өмнө дараах шинжилгээнээс алийг нь хийх нь хамгийн зөв бэ?

- A. Глюкоз тэсвэрлэх чадвар тодорхойлох сорил
- B. Глюкозжсон гемоглобин
- C. Өлөн үед сахарыг тодорхойлох
- D. Шээсээр ялгарах сахарыг хэмжих
- E. Генетикийн шинжилгээ хийх

/502./ 1-р хэлбэрийн диабеттэй өвчтөнд хоногт хэрэглэх инсулины дээд тун хэд байж болох вэ?

- A. 0.1 ед/кг
- B. 0.5 ед/кг
- C. 0.75 ед/кг
- D. 1.0 ед/кг
- E. 1.2 ед/кг

/503./ Жинхэнэ ББЭЭ-ийн эмчилгээнд хамгийн үр дүнтэй эмийн бэлдмэлийг нэрлэнэ үү

- A. Гонадотропин-рилизинг дааврын суперантогонист
- B. Decapeptyl-Depot
- C. Бусерелин (Suprefact)
- D. Андрокур
- E. Depot Provera

/504./ Монгол улсад 2012 оноос нярайн тандалт шинжилгээгээр дараах эмгэгүүдийг илрүүлдэг

1. Вируст гепатит
2. Аденогениталь хамшинж
3. Глюкоз -6- фосфатдегидрогеназын дутагдал
4. Төрөлхийн анхдагч гипотиреоз
5. Фенилкетонури

/505./ Хуурамч ББЭЭ нь гетеросексуаль хэлбэртэй үед:

1. Жинхэнэ ББЭЭ үед илрэх бүх шинжүүд ижил илэрнэ
2. Хөвгүүдэд хөх ургах ба төмсөг шодой нь томроогүй байна
3. Хөвгүүдэд төмсөг, охидод өндгөвч томорно
4. Охидод хэлүү томрох, эрэгтэй хэлбэрээр үсжилт бий болно
5. Охидод хөх ургах шинж умай, өндгөвч томрохгүйгээр илэрнэ

/506./ 1-р хэлбэрийн диабетийн онцлог хүүхдэд:

1. Хурц эхэлж хурдан даамжрах
2. Бага насанд гол төлөв оврогоор эхлэх
3. Хожуу үеийн хүндрэлд өртөх эрсдэл их
4. Бие бялдрын хөгжилд сөргөөр нөлөөлөх
5. Ээнэгшилд орохдоо амархан

/507./ Нойр булчирхайд хамааралтай тодорхойлолтод тохирохыг зөв сонгоно уу

1. Нойр булчирхайн эсгэгүүд хоол боловсруулалтанд оролцох
2. Дотоод шүүрлийн эдүүд дааврууд ялгаруулах
3. Дотоод шүүрлийн эдүүд лангергансийн арлын эсүүдээс тогтоно
4. Лангергансын арал 80-200 эстэй
5. “a”, “b” ба “d” эсүүд нь хоорондоо олон шинжээр ялгаатай

/508./ Диабетийн хожуу үеийн жижиг судасны хүндрэлд хамаарагдахыг зөв нэрлэнэ үү

1. Диабетийн нефропати
2. Диабетийн нейропати
3. Диабетийн ретинопати
4. Инфаркт миокард
5. Инсульт

/509./ Өнчин тархины одойролд хамаатай эмнэлзүйн шинжүүдийг зөв сонгоно уу

1. Өсөлтийн хоцрогдол
2. Бамбайн дааврын дутагдлын шинжүүд
3. Бэлгийн бойжилт хоцрох
4. Цусны сахар ихсэх
5. Биеийн пропорцын өөрчлөлт

/510./ Бэлгийн бойжилт эртсэх эмгэгт (ББЭЭ) тохирохыг зөв сонгоно уу

1. Охидод 7 нас, хөвгүүдэд 8 наснаас өмнө бэлгийн бойжилтын шинжүүд илрэхийг ББЭЭ гэнэ.
2. Жинхэнэ ба хуурамч ББЭЭ гэж ангилна
3. Бэлгийн хоёрдогч шинжүүд хүйстэйгээ тохирч байвал изо, эсрэг хүйсээ дагавал гетеросексуаль гэнэ
4. Жинхэнэ ББЭЭ нь гонадолиберин, гонадотропины ялгаралт ихэссэнээр бэлгийн даавруудын ялгаралтыг ихэсгэнэ
5. Ховор тохиолдолд шалтгаан тодорхойгүй (идиопатик) ББЭЭ тохиолдоно